

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ БАГЦ
ЖУРАМ**

- Хавсралт 1. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлага
- Хавсралт 2. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлага
- Хавсралт 3. Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогчийг бүртгэхэд тавигдах нөхцөл шаардлага

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны дүгээр тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой багц журам”-ийн нэгдүгээр хавсралт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос хөрөнгө оруулалтын менежментийн компани /цаашид “ХОМК” гэх/-ийн зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох болон түүний бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд тавих шаардлага, эрх, үүргийг тодорхойлох, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах, сангийн хөрөнгийг удирдахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. ХОМК Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.7.2-т заасан үнэт цаасыг итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хавсран эрхлэхтэй холбоотой харилцааг Хорооноос баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар зохицуулна.

1.3. Энэ журмаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахгүй.

Хоёр. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавих шаардлага

2.1. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 200 сая төгрөгөөс доошгүй байх;

2.1.2. энэ журамд заасан бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц болон бусад шаардлага;

2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.5-д заасан хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө оруулалтын зөвлөхүүд нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх;

2.1.4. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.3-т заасан хоёроос доошгүй хөрөнгө оруулалтын зөвлөхтэй байх.

2.1.5. сангийн хөрөнгөөр арилжаа хийх, брокерт захиалга өгөх, брокерийн баталгаажуулалтыг хүлээн авах, арилжааны төлбөрийг гүйцэтгэх, арилжааны гүйлгээтэй холбоотой мэдээллийг хадгалах, хөрөнгө оруулагчид мэдээлэл өгөх бэк оффис /back office/-ын программ хангамжтай байх.

2.2. Энэ журмын 2.1.1-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бусад мөнгөн хөрөнгөөс бүрдсэн байна.

Гурав. Бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн шаардлага

3.1. ХОМК гурваас доошгүй гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна.

3.2. ХОМК-ийн гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулалтын зөвлөхүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

3.2.1. хуульд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон

банк, даатгал, бусад санхүүгийн компанийн гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

3.2.2. банк, санхүүгийн зах зээлд гурваас доошгүй жил ажилласан туршлагатай, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн байх;

3.2.3. тухайн компанитай гэрээгээр ажилладаг кастодиан, үнэлгээний болон аудитийн компанийн эрх бүхий албан тушаалтан, үнэлгээчин, аудиторын холбогдох этгээд биш байх;

3.2.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбооноос үнэт цаасны зах зээл дээр хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллах эрх авсан байх.

3.3. Энэ журмын 3.1-д заасан төлөөлөн удирдах зөвлөл дараах журмыг баталсан байна:

3.3.1. төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;

3.3.2. дотоод хяналтын журам;

3.3.3. ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам;

3.3.4. үйл ажиллагааны эрсдэлийн журам;

3.3.5. ёс зүйн дүрэм;

3.3.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөө, эсхүл дотоод журам;

3.3.7. бусад шаардлагатай журам.

3.4. ХОМК Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт болон комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх нэгж, эсхүл хариуцсан ажилтантай байх бөгөөд түүнд төлөөлөн удирдах зөвлөл нь хяналт тавина.

3.5. ХОМК дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй байх ба уг нэгжийн чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогтой холбоотой зохицуулалтыг энэ журмын 3.3.2, 3.3.4-т тус тус заасан журамд дэлгэрэнгүй тусгана.

3.6. ХОМК нь банк, санхүү, даатгал, үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч компаниудын нэгдлийн оролцогч компани бол тэдгээрийн хооронд олон нийтэд нээлттэй бус мэдээлэл алдагдах, аливаа сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх зорилгоор үйл ажиллагааг заагласан тогтолцоо /chinese wall/-г бүрдүүлсэн байх бөгөөд түүнд хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг дотоод хяналтын журамдаа тусгасан байна.

3.7. ХОМК хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, маркетингийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөр арилжаа хийх, үнэт цаасны брокерт захиалга өгөх зэрэг төлбөрийн өмнөх үйл ажиллагааг үнэт цаасны брокерийн баталгаажуулалтыг хүлээн авах, арилжааны төлбөрийг гүйцэтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, тохируулга хийх, сангийн активыг үнэлэх, хөрөнгө оруулагчид мэдээлэх зэрэг үйл ажиллагаанаас тусгаарласан байна.

3.8. ХОМК-ийн комплаенс болон дотоод хяналтын үйл ажиллагаа нь тус тусдаа бие даасан байх ба үйл ажиллагаагаа төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад шууд тайлагнаж ажиллана.

3.9. Энэ журмын 3.5-д заасан дотоод хяналтын нэгж нь үйл ажиллагаандаа зохистой засаглал, хараат бус байх зарчмыг мөрдөж ажиллах ба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.9.1. компанийн үйл ажиллагааны бусад чиг үүргээс тусдаа байх;

3.9.2. аудитын ажлыг зохих ёсоор төлөвлөх, бүртгэх, хянах, түүнээс гарсан үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг тэмдэглэн хөтөлж, баримтжуулах;

3.9.3.аудитын тайланд онцолсон асуудлуудыг удирдлагад тухай бүр тайлагнаж шийдвэрлүүлэх.

Дөрөв. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага

4.1.Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 45.1-д зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлж, Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлнэ:

4.1.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу/;

4.1.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

4.1.3. компанийн хувьцаа эзэмшигчийн хурлаас гаргасан хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тухай шийдвэр, хурлын тэмдэглэл;

4.1.4. хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлого болохыг нотлох баримт, хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол сүүлийн гурав хүртэлх жилийн эцсийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, татвар төлөгчийг тодорхойлох баримт;

4.1.5. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхүүд нь дараах мэдээллийг ирүүлнэ:

4.1.5.1. дэлгэрэнгүй анкет /энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу/;

4.1.5.2. гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулалтын зөвлөхийн хувьд үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ эрхлэх эрхийн үнэмлэхний хуулбар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт.

4.1.6. энэ журмын 2.1.3-т заасан этгээдийн хувьд Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан талаарх болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.5.1-44.5.3-т заасан хориглолтыг зөрчөөгүй болох тухай нотлох баримт;

4.1.7. ажлын байр нь өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, түрээсийн байр бол түрээсийн гэрээний хуулбар;

4.1.8. тухайн компанийн гурван жилийн бизнесийн болон эрсдэлийн төлөвлөгөөг боловсруулахад ашигласан судалгааны тайлан;

4.1.9. энэ журмын 2.1.5-д заасан шаардлагыг хангасан бэк оффис /back office/-ын программ хангамжийн танилцуулга;

4.1.10. энэ журмын 3.3-т заасан дүрэм, журам;

4.1.11. энэ журмын 3.6-д заасан нөхцөлийг бүрдүүлсэн тухай танилцуулга;

4.1.12. зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай төлбөрийн баримт.

4.2. ХОМК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хүсэлтийг энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргаж, дараах баримт бичгийн хамт Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлнэ:

4.2.1. өөрчлөлт оруулах болсон эрх зүйн үндэслэлийг нотлох баримт;

4.2.2. ХОМК-ийн хувьцааг шилжүүлэн авч буй хувьцаа эзэмшигч нь тохиромжтой этгээд болох талаарх нотлох баримт, хувьцааг худалдан авч буй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт, гарал үүслийн талаарх тодорхойлолт;

4.2.3. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан зохицуулалттай этгээдийн дүрэмд орох нэмэлт, өөрчлөлтийн төсөл.

4.3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа ХОМК нь бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэж, ажлын 15 өдөрт багтаан улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

4.4. ХОМК нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагыг өөрчлөх хүсэлтийг энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргаж, дараах баримт бичгийн хамт Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлнэ:

4.4.1. томилогдсон этгээдийн товч намтар;

4.4.2. дээд боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

4.4.3. гүйцэтгэх удирдлагын хувьд үнэт цаасны зах зээлд ажиллах эрхийн үнэмлэхийн хуулбар;

4.4.4. томилсон эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.4.5. тохиромжтой этгээд эсэхийг тодорхойлох баримт бичиг.

4.5. Энэ журмын 4.8-д заасан хүсэлт, холбогдох баримт бичгийг Хороо холбогдох хууль тогтоомжийн дагуу ажлын таван өдрийн дотор хянаж, шийдвэрлэх бөгөөд уг хугацааг бүрдэл бүрэн хангагдсан баримт бичиг ирүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

4.6. ХОМК-ийн хөрөнгө оруулалтын зөвлөх өөрчлөгдсөн тохиолдолд Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан талаарх нотлох баримтыг холбогдох шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

4.7. Хороо энэ журмын 4.10-д заасан этгээд нь тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан эсэхийг ажлын хоёр өдрийн дотор хянах ба тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан гэж үзвэл ХОМК-д Хорооны албан бичгээр мэдэгдэнэ.

Тав. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа

5.1. ХОМК хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа үндэслэл бүхий тооцоо, судалгаанд суурилан, тодорхой аргачлалыг үндэслэнэ.

5.2. ХОМК нь урьдчилан тодорхойлсон хөрөнгө оруулалтын бодлого, эсхүл сангийн төрөл, хэлбэрийн дагуу хөрөнгө оруулалтын санг удирдах үүрэг хүлээсэн бол зөвхөн тухайн сангийн тодорхойлсон зорилт, хязгаарлалтад нийцүүлэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулна.

5.3. ХОМК нь сангийн бүх арилжааг гүйлгээний төрөл, хэмжээний хувьд зах зээлийг харгалзан үзсэний үндсэн дээр байж болох хамгийн сайн нөхцөлтэйгөөр гүйцэтгэн, сангийн активын үнэ цэнийг өсгөх зарчмыг баримтална.

5.4. ХОМК нь хувьцааны хуваарилалтыг харилцагчдадаа тэгш шударга хуваарилж, хэн нэгэнд давуу эрх олгон хуваарилахгүй бөгөөд хуваарилалтын бүхий л явцыг баримтжуулан баталгаажуулсан байна.

5.5. ХОМК нь талуудын харилцан тохиролцоогүй нөхцөлөөр хийгдсэн, хамгийн сайн гүйцэтгэлийн нөхцөлөөр хийсэн, бусад байгууллагын хураамжийн түвшингээс доогуур байхаас бусад тохиолдолд өөрийн холбоотой этгээдээр дамжуулан харилцагчийн нэрийн өмнөөс арилжаа хийхгүй.

5.6. ХОМК нь зах зээлийн бодит үнэд суурилан сангийн активын үнэлгээг тогтмол хийх ба үнэлгээ хийх аргачлал нь харилцагчдад нээлттэй ил тод байна.

5.7. Хөрөнгө оруулалтын сантай холбоотойгоор ХОМК нь сангийн цэвэр хөрөнгийн үнийг үнэн, зөв тооцоолохдоо үнэлгээ нь тухайн сангийн бодлогын баримт бичгийн дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавьсан байна.

5.8. ХОМК нь хөрөнгө оруулалтын эрсдэлийн эх үүсвэр, нөхцөл байдал, эрсдэлийн түвшнийг удирдах, тодорхойлох, хэмжих эрсдэлийн удирдлагын арга хэрэгсэлтэй байна.

5.9. ХОМК нь санхүүгийн зах зээлийн гэнэтийн хямрал, давагдашгүй хүчин зүйлийн үед авч хэрэгжүүлэх бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.

5.10. ХОМК нь хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой хийсэн судалгаа, өгсөн зөвлөгөө, болон авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг хадгалах ба бүртгэлийг аюулгүй найдвартай хадгалах үйл ажиллагааг дотоод дүрэм, журмаар тодорхой зохицуулсан байна.

5.11. ХОМК нь түүнд итгэмжлэгдсэн хөрөнгийн аюулгүй, найдвартай хадгалалтыг хариуцан, хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодианы санхүүгийн чадавхад байнгын хяналт тавьж ажиллана.

5.12. ХОМК нь дотоод бүртгэлийг тооцооны байгууллага, банк, кастодиан, харилцагч болон брокер зэрэг гуравдагч этгээдүүдээс гаргасан бүртгэлтэй сар бүр тулган баталгаажуулах бөгөөд бүртгэлийн зөрүү гарсан тохиолдолд түүнийг тогтоож, залруулах үйл ажиллагааг гүйцэтгэн, энэ талаар залруулгын бүртгэл хөтөлнө.

5.13. ХОМК нь хамтын хаалттай ХОС-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлдэг бол уг сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувиас доошгүй хэмжээгээр хөрөнгө оруулалт хийж, уг хязгаараас буурсан тохиолдолд нэмэлт хөрөнгө оруулалтыг тухай бүр санд оруулна.

5.14. ХОМК энэ журмын 5.13-т заасан оруулсан хөрөнгөө зөвхөн сангийн үйл ажиллагааны хугацаа дуусгавар болж, бүх өр төлбөрийг барагдуулан бусад нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийг хуваарилсны дараа эргүүлж авна.

Зургаа. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ

6.1. ХОМК нь хөрөнгийн оруулалтын сангийн активын удирдлагыг хэрэгжүүлэх хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г байгуулсны үндсэн дээр холбогдох үйлчилгээг үзүүлнэ.

6.2. Энэ журмын 6.1-д заасан гэрээнд дараах зүйлийг тусгана:

6.2.1. итгэмжлэн удирдах сангийн актив, үнэт цаасны төрөл, хувь хэмжээ;

6.2.2. талуудын эрх, үүрэг;

6.2.3. сангийн нэгж эрхийг эргүүлэн худалдаж авах зохицуулалт;

6.2.4. үйлчилгээний төлбөр, урамшуулал болон түүнтэй холбоотой бусад мэдээлэл;

6.2.5. хөрөнгө итгэмжлэн удирдах хөрөнгийн удирдлага;

6.2.6. гэрээг цуцлах үндэслэл, журам;

6.2.7. давагдашгүй хүчин зүйл /форс-мажор/-ийн нөхцөлүүд;

6.2.8. хэрэглэх хууль тогтоомжийн хүрээ болон маргаан шийдвэрлэх журам;

6.2.9. хуулиар хориглоогүй бусад шаардлагатай мэдээлэл.

6.3. Энэ журмын 6.1-д заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол ХОМК-ийн үйлчилгээний хөлс,

урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах хугацаанд өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын шийдвэрээр өөрчлөлт оруулна.

6.4. Энэ журмын 6.3-т заасны дагуу гэрээнд орсон өөрчлөлтийг ажлын гурван өдрийн дотор Хороо болон сангийн нэгж эрх эзэмшигчид мэдээлнэ.

Долоо. ХОМК-ийн үүрэг

7.1. ХОМК Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.8, 47.2-т заасан нийтлэг үүргээс гадна дараах үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1. Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах;

7.1.2. хөрөнгө оруулагчийн эрх ашгийг тэргүүн ээлжинд тавьж, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах;

7.1.3. ХОС-ийн хөрөнгө оруулалтын багц, эрсдэлийн удирдлагыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг стандарт зөвлөмж, сангийн дотоод дүрэм, журмын хүрээнд хэрэгжүүлэх;

7.1.4. хамтын ХОС-ийн хувьд хөрөнгө оруулалт хийх боломжтой хөрөнгө оруулалтын хэрэгслийн талаар төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

7.1.5. хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, стратегийн хүрээнд сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж, хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай бүх хүчин чармайлт гаргаж ажиллах;

7.1.6. хамтын ХОС-ийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр сангийн хөрөнгийг хадгалах, хөрөнгө итгэмжлэн удирдахтай холбоотой аливаа гэрээ, хэлцлийг тухайн сангийн нэрийн өмнөөс байгуулахгүй байх;

7.1.7. нэгээс дээш тооны ХОС-д үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд сан тус бүрийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, стратеги, дотоод дүрэм, журмын хүрээнд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, тэдгээрийн хооронд сонирхлыг зөрчил үүсгэхээс сэргийлж, шударга, ил тод байх зарчмыг мөрдөж ажиллах;

7.1.8. харилцагчийг таньж мэдэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх чиглэлээр сангийн дотоод дүрэм, журам, хөтөлбөрт заасан арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;

7.1.9. ХОМК-ийн эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө оруулалтын зөвлөх нь ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж ажиллах.

“Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 1 дүгээр хавсралт

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Хүсэлт гаргагчийн талаарх мэдээлэл						
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Үйл ажиллагааны цэвэр ашиг /төгрөгөөр/						
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="radio"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="radio"/> Гадаадын хөрөнгө оруулалттай					
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Цахим шуудангийн хаяг						
Цахим хуудас						
Удирдлага, мэргэшсэн хүний нөөцтэй холбоотой мэдээлэл:						
Нийт ажилтан, албан хаагчдын тоо						
Албан тушаал	Овог, нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар
ТУЗ-ийн дарга						
ТУЗ-ийн гишүүд						
Гүйцэтгэх захирал						
Мэргэшсэн нягтлан бодогч						
Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх						
Бусад						
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:						
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ						

Хувьцаа эзэмшигчдийн овог, нэр/хуулийн этгээдийн нэр	Хувьца аны тоо ширхэг	Хувьцааны төрөл		Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
Ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн талаарх мэдээлэл					
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалда н авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ /төгрөгөөр/
Программ хангамжийн нэр төрөл	Программы н зориулалт	Худалда н авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ /төгрөгөөр/

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа мэдээлэл, нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв уг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно уу.

Бид үйл ажиллагаандаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн хангаж, биелүүлж ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд /тохирохыг сонгож “\” тэмдэглээ хийнэ./:

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Овог, нэр: Регистрийн дугаар:

Албан тушаал: Утасны дугаар:


Өргөдөл гаргагч:
Хуулийн этгээдийн
Тэмдэг

_____ /_____/
/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

**ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН БУСАД МЭРГЭШСЭН ХҮНИЙ
НӨӨЦИЙН
ТОДОРХОЙЛОЛТ**

1. Ерөнхий мэдээлэл

Ургийн овог:	
Овог нэр:	
Регистрийн дугаар:	
Иргэний харьяалал:	
Хүсэлт гаргагчид эрхлэх албан тушаал:	
Оршин суугаа газрын хаяг:	
Гар утасны дугаар:	
Цахим шуудангийн хаяг:	



2. Боловсрол /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн огноо	Төгссөн огноо	Диплом, гэрчилгээний дугаар

3. Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Шалтгаан

4. ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага бусад мэргэшсэн хүний нөөцийн холбогдох этгээдийн байдал

№	Таны хэн болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал

Миний бие дээр мэдүүлсэн мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв болохыг баталж байна.

Тодорхойлолт гаргасан:

/...../ /...../

/овог, нэр/

/гарын үсэг/

/огноо/

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр		
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр							
Улсын бүртгэлийн дугаар							
Регистрийн дугаар							
Дараах төрлөөс сонгоно уу.							
<ul style="list-style-type: none"> ○ Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах ○ Хувьцаа эзэмшигчид өөрчлөлт оруулах ○ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт оруулах 							
Хэсэг 1. Хувь нийлүүлсэн хөрөнгө /ХНХ/-ийн хэмжээнд өөрчлөлт оруулах							
Овог, нэр/ Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Одоогийн ХНХ-ийн хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлт орсны дараах ХНХ-ийн хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь	
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)</i>							
Хэсэг 2. Хувьцаа эзэмшигчид өөрчлөлт оруулах							
Овог, нэр/ Хуулийн этгээдийн нэр	Эцсийн өмчлөгч эсэх	ХНХ-ийн 5, түүнээс дээш хувийг эзэмшдэг эсэх	Харьяалал	Регистрийн дугаар	Хувьцааны тоо (ш)	ХНХ-ийн хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь
Хэсэг 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт оруулах							
Албан тушаал	Овог нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Мэргэжил	Утасны дугаар		

Өргөдөл гаргасан:

/...../ /...../

/овог, нэр/

/гарын үсэг/

/огноо/

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны дүгээр тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой багц журам”-ийн хоёрдугаар хавсралт

“ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос хөрөнгө оруулалтын сан /цаашид “ХОС” гэх/-г үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх, хамтын ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд санал болгох, худалдах болон хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, хамтын ХОС-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сангийн бүтэц, зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдал, сангийн активт тавих шаардлагыг тогтоох, гадаад улсад бүртгэлтэй ХОС-г бүртгэх, санг өөрчлөн зохион байгуулах, татан буулгахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.5.3-т заасан Хорооноос зөвшөөрсөн бусад төрлийн хамтын ХОС-г үүсгэн байгуулах, сангийн нэгж эрхийг санал болгох, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх, түүний үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Энэ журмаар хамтын хаалттай ХОС-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээлд арилжигдаж буй нэгж эрхийг худалдах, худалдан авахтай холбогдсон харилцааг зохицуулахгүй.

1.4. Хорооны зөвшөөрөлгүйгээр хамтын ХОС-ийн нэгж эрхийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээ ашиглан нийтэд санал болгохгүй бөгөөд хамтын сангийн нэгж эрхийг бүртгүүлэхээс өмнөх бэлтгэл үе шатанд стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдтэй хөрөнгө оруулалт татах талаар урьдчилан яриа, хэлэлцээр хийхийг нэгж эрхийг нийтэд санал болгосонд тооцохгүй.

1.5. Хуульд өөрөөр заагаагүй бол хувийн ХОС-ийн нэгж эрхийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээ ашиглан нийтэд санал болгох замаар хөрөнгө татан төвлөрүүлэхгүй бөгөөд зөвхөн хаалттай хүрээнд нэгж эрхээ санал болгон худалдана.

1.6. Хамтын ХОС-ийн нэгж эрхийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн журмаар зохицуулна.

Хоёр. ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлэх хүсэлт гаргах, хүсэлтийг хянах

2.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.5.3-т заасан Хорооноос зөвшөөрсөн бусад төрлийн ХОС гэдэгт биржээр арилжаалагддаг сангийн төрөлтэй хамтын санг тооцно.

2.2. Үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани /цаашид “ХОМК” гэх/ нь ХОС-г үүсгэн байгуулах ажиллагааг эхлүүлэхээс өмнөх үе шатанд дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

2.2.1. ХОС-г үүсгэн байгуулах шийдвэр, сангийн дүрэм, сангийн нэгж эрхийн танилцуулга, багц журам, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг болон бусад шаардлагатай баримт бичгийн төслүүдийг боловсруулах;

2.2.2. үүсгэн байгуулах ХОС-ийн хуулийн этгээдийн оноосон нэрийг сонгож, уг нэрийг баталгаажуулах;

2.2.3. ХОС-ийн хөрөнгийг итгэмжлэн удирдах, хадгалах үйлчилгээ авах болон ХОС-ийн нэгж эрхийг бусад худалдахтай холбоотой гэрээний төслүүдийг боловсруулах;

2.2.4. зах зээлийн нөхцөл байдал болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулах чиглэлээр холбогдох тооцоо судалгааг хийж гүйцэтгэсний үндсэн дээр үүсгэн байгуулах ХОС-ийн хөрөнгө оруулалтын салбар, чиглэлийг тодорхойлж, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах.

2.3. Хамтын нээлттэй, хаалттай, биржээр арилжаалагддаг ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлэх хүсэлтийг гаргахдаа дараах баримт бичгийн хамт ирүүлнэ:

2.3.1. үүсгэн байгуулагч ХОМК-ийн хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар болон компанийн товч танилцуулга;

2.3.2. ХОС-г үүсгэн байгуулах тухай ХОМК-ийн шийдвэр;

2.3.3. ХОС-ийн дүрмийн төсөл болон хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг;

2.3.4. ХОМК-тай байгуулах хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээний төсөл;

2.3.5. кастодиантай байгуулах хөрөнгө хадгалах үйлчилгээний гэрээний төсөл;

2.3.6. ХОС-ийн тухай хуулийн 25.1-д заасан ХОС-ийн багц журмын төсөл, хөрөнгө итгэмжлэн удирдах журмын болон татан буулгах ажиллагааны журмын төсөл;

2.3.7. ХОС-г нэгээс дээш тооны ХОМК-тай хамтран үүсгэн байгуулж байгаа бол тэдгээрийн хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.2-г заасан гэрээний эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар;

2.3.8. үүсгэн байгуулагч ХОМК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага нь тохиромжтой этгээд мөн болох болон тэдгээрийн ур чадвар, туршлагын талаарх дэлгэрэнгүй тодорхойлолт;

2.3.9. үүсгэн байгуулагч ХОМК-ийн зүгээс ХОС-д оруулах хөрөнгийн хэмжээ, уг хөрөнгийг оруулах санхүүгийн чадавх, гарал үүслийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2.3.10. ХОС-г үүсгэн байгуулах ажиллагааны нийт төсөв, зардал, уг зардлыг санхүүжүүлэх чадавх, өөрийн хөрөнгийн хүрэлцээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2.3.11. стратегийн хөрөнгө оруулагч, мэргэжлийн хөрөнгө оруулагч болон бусад хөрөнгө оруулагчдын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээрийн санд оруулахаар төлөвлөсөн хөрөнгийн нийт хэмжээ, урьдчилан яриа, хэлэлцээр хийсэн тохиолдолд энэ талаар нотлох баримт бичиг;

2.3.12. ХОС-г үүсгэн байгуулах баримт бичиг, холбогдох тооцоо судалгааг гүйцэтгэхэд оролцсон хууль зүйн зөвлөгөө болон бусад үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2.3.13. хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн хувьд үүсгэн байгуулах, анхдагч зах зээлд нэгж эрхийг солилцох ажиллагаанд оролцох мэргэжлийн оролцогчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, түүнтэй байгуулсан холбогдох үйлчилгээ үзүүлэх болон санхүүгийн хэрэгслийг нэгж эрхээр солих гэрээний төсөл, ХОС-ийн нэгж эрхийг санхүүгийн хэрэгслээр солих болон нэгж эрхийг буцаан худалдах, дахин нэгж эрх гаргахтай холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан журмын төсөл;

2.3.14. хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн хувьд сангийн нэгж эрхийг солих мэргэжлийн оролцогчийн санхүүгийн хэрэгсэл нь аливаа өмчлөх эрхийн зөрчилгүй болох талаар

ноглох баримт бичиг, нэгж эрхийг солих санхүүгийн хэрэгслийн үнэ, тоо хэмжээ, түүний дэлгэрэнгүй жагсаалт;

2.3.15. хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн хувьд ХОС болон мэргэжлийн оролцогчийн хооронд нэгж эрхийг анхдагч болон хоёрдогч зах зээлд тогтмол солилцоход кастодианаас өмчлөх эрхийг шилжүүлэх, тухайлсан бүртгэлийг хөтлөхтэй холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан журмын төсөл;

2.3.16. хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн хувьд мэргэжлийн оролцогч байгууллага, эсхүл зах зээл үүсгэгч сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааны эрэлт, нийлүүлэлтийг хангах талаарх мэдээлэл, цэвэр активын үнэлгээг тооцох арга аргачлал, сангийн нэгж эрхийг бүртгүүлэх арилжаа эрхлэх байгууллагын талаарх мэдээлэл;

2.3.17. хамтын нээлттэй ХОС-ийн хувьд хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын бодлого, сан нэгж эрхээ буцаан худалдан авахтай холбоотой хязгаарлалтын аргууд, захиалгыг түдгэлзүүлэх нөхцөлтэй холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, ногдол ашгийн бодлогын журам;

2.3.18. нийтэд санал болгон гаргах нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах ажиллагааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, эсхүл биржийн бус зах зээлээр дамжуулан зохион байгуулах хамтын хаалттай ХОС-ийн хувьд сангийн нэгж эрхийг бүртгүүлэх арилжаа эрхлэх байгууллага, эсхүл мэргэжлийн холбооны талаарх холбогдох мэдээлэл;

2.3.19. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

2.4. Хувийн ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлэх хүсэлтийг энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу гаргаж, дараах баримт бичгийн хамт ирүүлнэ:

2.4.1. үүсгэн байгуулагч ХОМК-ийн хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар, компанийн товч танилцуулга, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага нь тохиромжтой этгээд мөн болох болон тэдгээрийн ур чадвар, туршлагын талаарх дэлгэрэнгүй тодорхойлолт;

2.4.2. ХОС-г үүсгэн байгуулах тухай ХОМК-ийн шийдвэр, үйлчилгээ үзүүлж байгаа бусад ХОС-ийн талаарх мэдээлэл;

2.4.3. ХОС-ийн нэгж эрхийн танилцуулга;

2.4.4. ХОС-ийн дүрмийн төсөл болон хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг;

2.4.5. ХОМК-тай байгуулах хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээний төсөл;

2.4.6. кастодиантай байгуулах хөрөнгө хадгалах үйлчилгээний гэрээний төсөл;

2.4.7. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 25.1.1-25.1.7, 25.1.9-25.1.11-д заасан журмын төсөл, хөрөнгө итгэмжлэн удирдах журмын болон татан буулгах ажиллагааны журмын төсөл;

2.4.8. ХОС-г нэгээс дээш тооны ХОМК хамтран үүсгэн байгуулж байгаа бол тэдгээрийн хооронд байгуулсан ХОС-ийн тухай хуулийн 14.2-т заасан гэрээний эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар;

2.4.9. үл хөдлөх хөрөнгийн хувийн ХОС-ийн хувьд үл хөдлөх хөрөнгийн салбарын талаарх судалгаа, оруулах хөрөнгийн жагсаалт, хөрөнгийн үнэлгээ, сангийн хөрөнгийг барьцаалан зээл авахтай холбоотой судалгааны тайлан, танилцуулга;

2.4.10. хувийн ХОС-ийн нэгж эрхийг худалдан авах сонирхлоо илэрхийлсэн мэргэжлийн хөрөнгө оруулагчдын мэдээлэл, амлалт, тандан судалгаа, үнэт цаасны брокерийн компаниар

дамжуулан хаалттай хүрээнд санал болгох нөхцөлд хамтран ажиллах гэрээний төсөл;

2.4.11. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

2.5. Энэ журмын 2.3.8, 2.4.1-д тус тус заасан этгээд нь тохиромжтой этгээд болох талаарх тодорхойлолтыг Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагын дагуу гаргаж ирүүлнэ.

2.6. Энэ журмын 2.4.3-т заасан хувийн ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгад сангийн нэгж эрхийн нэрлэсэн үнэ болон хөрөнгө оруулагчдад санал болгох үнэ, хөрөнгө оруулалтын стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын эрсдэл, сангийн бүтэц зохион байгуулалтын талаар тусгасан байна.

2.7. Энэ журмын 2.3.3, 2.4.4-т тус тус заасан ХОС-ийн дүрэм болон хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 16.1, 17.1-д тус тус заасан зүйлийг тусгасан байна.

2.8. ХОМК нь ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг энэ журамд заасан зохих шаардлагын дагуу бүрдүүлж, Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлнэ.

2.9. Хороо ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 20 өдөрт багтаан хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

2.10. Энэ журмын 2.3, 2.4-т тус тус заасан баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт тодруулга, мэдээлэл шаардлагатай тохиолдолд Хороо албан бичгээр ХОМК-д мэдэгдэх бөгөөд зохих шаардлага хангасан, бүрдэл бүрэн нэмэлт баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хянаж, санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

2.11. Хороо ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд санг үүсгэн байгуулах ажиллагааг дуусгавар болгож, энэ талаар хүсэлт гаргагч ХОМК-д албан бичгээр ажлын гурван өдрийн дотор мэдэгдэнэ.

Гурав. ХОС-г үүсгэн байгуулах

3.1. Хороо энэ журмын 2.9-д заасны дагуу ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэн өдрөөс хойш нэг сарын дотор ХОМК нь санг үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.

3.2. Энэ журмын 3.1-д заасан хугацаанд ХОМК нь ХОС-г хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг гаргаагүй тохиолдолд Хороо тухайн ХОС-ийн үүсгэн байгуулах баримт бичгийн бүртгэлийг хүчингүй болгоно.

3.3. ХОС-г үүсгэн байгуулах хурлаар сангийн дүрэм, энэ журмын 2.3.6, 2.4.7-д заасан журмуудыг баталж, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоос гадна хөрөнгө итгэмжлэн удирдах болон хөрөнгө хадгалах гэрээг ХОМК, кастодиантай байгуулсны үндсэн дээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.4. Хувийн ХОС-ийн хувьд сангийн нэгж эрхийн танилцуулгад тусгасан санал болгох үнээр нэгж эрхийг үүсгэн байгуулагч ХОМК болон бусад хөрөнгө оруулагчдад худалдах бөгөөд хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодиан дахь сангийн холбогдох дансанд нэгж эрхийн төлбөрийг тусгаарлан байршуулсны үндсэн дээр сангийн нэгж эрхийг шилжүүлэн бүртгэнэ.

3.5. Хувийн ХОС-ийн хувьд хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүртэлх хугацаанд энэ журмын 3.4-т заасан кастодиан дахь сангийн дансанд байршсан хөрөнгийг тухайн ХОС болон ХОМК зарцуулах эрхгүй байна.

3.6. Үүсгэн байгуулагч ХОМК-д худалдах сангийн нэгж эрхийн үнэ нь тухайн ХОС-ийн нэгж эрхийг бусад хөрөнгө оруулагчдад санал болгон худалдах үнээс багагүй байна.

3.7. Хувийн ХОС-ийн хувьд хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг дараах баримт бичгийн хамт Хороонд хүргүүлж, мэдэгдсэний үндсэн дээр ХОС-ийн үйл ажиллагааг эхэлсэнд тооцно:

3.7.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.7.2. энэ журмын 2.4.4-2.4.7-д тус тус заасан төсөл хэлбэрээр Хороонд бүртгүүлсэн баримт бичгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.7.3. Хороонд бүртгүүлсэн баримт бичигт өөрчлөлт орсон бол энэ талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох өөрчлөлтийн үндэслэл;

3.7.4. ХОС-ийн эрх бүхий албан тушаалтан, үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх өөрчлөгдсөн бол тэдгээр нь тохиромжтой этгээд мөн болох тухай болон ур чадвар, туршлагын талаарх дэлгэрэнгүй тодорхойлолт.

Дөрөв. Хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэх, нийтэд танилцуулах

4.1. Хамтын ХОС-ийн хувьд хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор сангийн нэгж эрхийн танилцуулгыг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт Хороонд бүртгүүлэхээр ирүүлнэ.

4.2. Хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгад Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.11-д зааснаас гадна дараах мэдээллийг тусгана:

4.2.1. энэ журамд заасан хамтын ХОС-ийн ангилал, сангийн активт тавих шаардлага, хөрөнгө оруулалт хийх санхүүгийн хэрэгслийн талаарх мэдээлэл;

4.2.2. хамтын нээлттэй ХОС-ийн хувьд нэгж эрх эзэмшигчээс санд нэгж эрхээ буцаан худалдах нөхцөл, төлөх шимтгэл, хураамж, захиалга биелүүлэх хугацаа, нэгж эрхийг эргүүлэн худалдан авахтай холбоотой хязгаарлалт, бусад нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтын талаарх мэдээлэл;

4.2.3. хамтын нээлттэй болон хаалттай ХОС-ийн хувьд нэгж эрхийг анхдагч зах зээлд санал болгон худалдах арга хэлбэр, нэгж эрхийн үнийг тодорхойлсон аргачлал, нэгж эрх худалдан авах захиалгыг биелүүлэх хугацааны мэдээлэл;

4.2.4. ХОМК, кастодиан, аудитын компанийн ерөнхий танилцуулга, туршлага, боловсон хүчний мэдээлэл, тэдгээрийн эрх үүргийн талаарх мэдээлэл;

4.2.5. ХОС-ийн гүйцэтгэлийг хэмжих үзүүлэлтүүд, бусад сангуудтай харьцуулсан судалгаа;

4.2.6. ХОС-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмын талаарх товч мэдээлэл, нэгж эрх эзэмшигчийн эрх үүрэг, нэгж эрх худалдах, худалдан авах захиалга өгөх үе шат, дарааллын талаарх мэдээлэл;

4.2.7. ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдэд сангийн орлогоор ногдол ашиг хуваарилах нөхцөл, бодлого;

4.2.8. хамтын хаалттай ХОС-ийн хувьд нэгж эрхээ арилжаалах арилжаа эрхлэх байгууллагын тухай мэдээлэл.

4.3. Хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгын эхний хуудсанд дараах анхааруулгыг тодоор бичсэн байна:

“хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгыг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь уг

сангийн нэгж эрхийн эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэ сангийн нэгж эрхийг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, сангийн бодлогын баримт бичиг, нэгж эрх гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.”

4.4. Энэ журмын 4.1-д заасан хугацаанд ХОМК нь сангийн нэгж эрхийн танилцуулгыг Хороонд бүртгүүлэх хүсэлт гаргаагүй тохиолдолд тухайн хамтын ХОС-г үүсгэн байгуулах ажиллагааг дуусгавар болгох бөгөөд энэ талаар хүсэлт гаргагч ХОМК-д Хорооны даргын албан бичгээр мэдэгдэнэ.

4.5. Хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулга, холбогдох баримт бичгийг Хороо хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор бүртгэх эсэхийг шийдвэрлэх бөгөөд уг хугацааг бүрдэл бүрэн хангагдсан баримт бичиг ирүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

4.6. Хороо нь хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд уг шийдвэрийг гарснаас хойш нэг сарын дотор тухайн санг татан буулгах ажиллагааг үүсгэн байгуулагч ХОМК гүйцэтгэнэ.

4.7. Хороо хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэх хүсэлтийг шийдвэрлэх явцад шаардлагатай нэмэлт мэдээлэл, баримт бичгийг ХОМК болон тухайн санд холбогдох үйлчилгээг үзүүлсэн этгээдээс шаардаж болно.

4.8. Хамтын ХОС-ийн нэгж эрхийг нийтэд санал болгох ажиллагааг гүйцэтгэхдээ нэгж эрхийн танилцуулгыг сонирхогч этгээд үнэ төлбөргүйгээр танилцах боломжийг бүрдүүлсэн байна.

4.9. ХОМК нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.5-д заасны дагуу хамтын ХОС-ийн нэгж эрхийг танилцуулгыг Хороонд бүртгүүлснээс хойш зургаан сарын хугацаанд нийтэд танилцуулна.

4.10. Энэ журмын 4.9-т заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд Хороо хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэсэн шийдвэрийг хүчингүй болгож, үүсгэсэн санг татан буулгах арга хэмжээ авахыг ХОМК-д даалгаж, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллах бөгөөд хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгыг шинэчлэн бүртгэхгүй.

4.11. Хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн хувьд нэгж эрхийг нийтэд танилцуулах ажиллагааг хэрэгжүүлэхгүй бөгөөд тухайн сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд санхүүгийн хэрэгслээр солих ажиллагааг хэрэгжүүлнэ.

Тав. Хамтын нээлттэй болон хаалттай ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд санал болгон худалдах, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх

5.1. Хамтын ХОС-ийн нэгж эрхийн танилцуулгыг Хороо бүртгэсэн тохиолдолд ХОМК нь нэгж эрхийг олон нийтэд танилцуулж, хөрөнгө татан төвлөрүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.

5.2. ХОМК тухайн хамтын ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд зөвхөн мөнгөн хөрөнгөөр хөрөнгө оруулагчдад санал болгон худалдана.

5.3. Хамтын ХОС-ийн олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгө буюу активын доод хэмжээ нь 1 тэрбум төгрөгөөс доошгүй байна.

5.4. Хамтын ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд хөрөнгө оруулагчдад санал болгон худалдах замаар татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг тухайн сантай хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодианы тусгаарласан дансанд байршуулна.

5.5. Хорооноос хамтын ХОС-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох хүртэлх хугацаанд тухайн сан болон ХОМК энэ журмын 5.4-т заасан мөнгөн хөрөнгийг зарцуулах эрхгүй байна.

5.6. ХОМК нь хамтын ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг нэг сарын хугацаанд зохион байгуулж, нэгж эрхийн танилцуулгад тусгасан хэмжээнд хөрөнгийг татан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулна.

5.7. ХОМК нь хамтын хаалттай ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, эсхүл биржийн бус зах зээлээр дамжуулан зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд арилжаа эрхлэх байгууллага, мэргэжлийн холбоо нь сангийн нэгж эрхийг өөрийн бүртгэлд бүртгэх, анхдагч зах зээлд санал болгон худалдах, байршуулах, хоёрдогч зах зээлийн арилжааг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг тогтоож, Хороогоор батламжлуулна.

5.8. Хамтын хаалттай ХОС-ийн хувьд ХОМК нь сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд хөтөлбөрийн буюу үе шаттайгаар санал болгон худалдах замаар сангийн нэгж эрхийн танилцуулгад тусгасан мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлэхгүй.

5.9. Хамтын нээлттэй ХОС-ийн хувьд ХОМК нь нэгж эрхийг анхдагч зах зээлд санал болгон худалдах, байршуулах, захиалгын бүртгэлийг хийх ажиллагааг андеррайтерийн компанитай хамтран зохион байгуулж болно.

5.10. ХОМК нь энэ журмын 5.1-д заасны дагуу хамтын ХОС-ийн нэгж эрхийг олон нийтэд танилцуулах, сурталчлах болон худалдах хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэнэ.

5.11. ХОМК нь хамтын ХОС-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдаж, сангийн нэгж эрхийн танилцуулгад заасан мөнгөн хөрөнгийг амжилттай татан төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын гурван өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг хамтын ХОС-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтийн хамт Хороонд ирүүлнэ.

5.12. Кастодиан нь хамтын нээлттэй ХОС-ийн нэгж эрх хасагдах, нэмэгдэх тухай бүр холбогдох өөрчлөлтийг эзэмшигч тус бүрээр бүртгэх, хадгалах, шилжүүлэх, цэвэр активын үнэлгээний тооцоололд хяналт тавьж ажиллана.

Зургаа. Хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд санхүүгийн хэрэгслээр солилцох, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх

6.1. Хуульд өөрөөр заагаагүй бол хамтын биржээр арилжаалагддаг ХОС нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан санхүүгийн хэрэгслээр нэгж эрхээ анхдагч зах зээлд солилцох замаар сангийн актив буюу багц хөрөнгөө бүрдүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд сангийн активын доод хэмжээнд шаардлага тавихгүй.

6.2. Хамтын биржээр арилжаалагддаг ХОС нь энэ журмын 6.1-д заасан нэгж эрхээ анхдагч зах зээлд санал болгож, санхүүгийн хэрэгслээр солилцох ажиллагааг үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий үнэт цаасны компани /цаашид “мэргэжлийн оролцогч” гэх/-аар дамжуулан зохион байгуулна.

6.3. Мэргэжлийн оролцогч нь хамтын биржээр арилжаалагддаг ХОС-тай нэгж эрхийг анхдагч зах зээлд санхүүгийн хэрэгслээр солилцох гэрээг бичгээр байгуулах бөгөөд уг гэрээг нэг талаас мэргэжлийн оролцогч, нөгөө талаас ХОС-г төлөөлөн ХОМК байгуулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

6.4. Энэ журмын 6.3-т заасан нэгж эрхийг санхүүгийн хэрэгслээр солилцох гэрээнд дараах мэдээллийг тусгасан байна:

6.4.1. солих нэгж эрхийн тоо ширхэг, үнэ, дээд, доод хязгаар;

6.4.2. нэгж эрхийг солих санхүүгийн хэрэгслийн тоо ширхэг, үнэ;

6.4.3. нэгж эрхийг анхдагч, хоёрдогч зах зээлд солих нөхцөл, хэрэгжүүлэх хугацаа, давтамж;

6.4.4.ХОМК, хамтын биржээр арилжаалагддаг ХОС, мэргэжлийн оролцогчийн эрх, үүрэг, гэрээний хугацаа;

6.4.5.бусад.

6.5. Хамтын биржээр арилжаалагддаг ХОС-тай хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодиан нь мэргэжлийн оролцогч болон сангийн хооронд нэгж эрх, санхүүгийн хэрэгслийн өмчлөх эрхийг шилжүүлэх, тухайлсан бүртгэлийг хөтлөх ажиллагааг чирэгдэлгүй, шуурхай байдлаар зохион байгуулж ажиллах бөгөөд анхдагч, хоёрдогч зах зээлд нэгж эрхийг санхүүгийн хэрэгслээр солиход программ хангамж, дүрэм, журмын хүрээнд саадгүй хийгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

6.6. Кастодиан нь энэ журмын 6.5-д заасан үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан журмыг тогтоож, үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж ажиллах үүрэгтэй.

6.7. ХОМК шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд санхүүгийн хэрэгслээр солих ажиллагааг нэг болон түүнээс дээш мэргэжлийн оролцогчтой гэрээ байгуулах замаар хамтран хэрэгжүүлж болно.

6.8. ХОМК нь энэ журмын 6.1-д заасны дагуу хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд санхүүгийн хэрэгслээр солих хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэнэ.

6.9. ХОМК нь хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд санхүүгийн хэрэгслээр сольж, сангийн нэгж эрхийн танилцуулгад заасан сангийн активыг амжилттай бүрдүүлэн өмчлөх эрхийн бүртгэлийг кастодианаар баталгаажуулсан өдрөөс хойш ажлын гурван өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг Хороонд ирүүлнэ.

6.10. ХОМК нь энэ журмын 6.9-т заасан тайланг ирүүлэхдээ хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт, арилжаа эрхлэх байгууллагын нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааны бэлтгэл хангагдсан тухай дүгнэлтийн хамт Хороонд ирүүлнэ.

6.11. Мэргэжлийн оролцогч нь зах зээлийн нөхцөл байдал, санхүүгийн чадавх, активын багцыг бүрдүүлэх санхүүгийн хэрэгслийн хөрвөх чадвар хангалтгүйгээс шалтгаалан хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн нэгж эрхийг анхдагч зах зээлд санхүүгийн хэрэгслээр солих ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд сангийн нийт нэгж эрхийн 30 хүртэлх хувийг мөнгөн хөрөнгөөр худалдан авч болно.

Долоо. Зөвшөөрлийн нөхцөл, шаардлага

7.1. Хамтын нээлттэй болон хаалттай ХОС-ийн хувьд ХОМК нь энэ журмын 4.9-т заасан хугацаанд нэгж эрхийг нийтэд танилцуулж, сангийн дүрэмд заасан доод хэмжээнд хөрөнгийг татан төвлөрүүлээгүй тохиолдолд Хороо тухайн хамтын санг үүсгэн байгуулах ажиллагааг зогсоож, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй.

7.2. Хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн хувьд ХОМК энэ журмын 4.9-т заасан хугацаанд нэгж эрхийг анхдагч зах зээлд санхүүгийн хэрэгслээр солих ажиллагааг хэрэгжүүлж, сангийн дүрэм, нэгж эрхийн танилцуулгад тусгасан активын багцыг бүрдүүлээгүй тохиолдолд Хороо тухайн сангийн үүсгэн байгуулах ажиллагааг зогсоож, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй.

7.3. Хамтын нээлттэй, хаалттай, биржээр арилжаалагддаг ХОС нь сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах өргөдлийг энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу гаргаж, дараах баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ:

7.3.1. хамтын нээлттэй, хаалттай, биржээр арилжаалагддаг ХОС-ийн дүрэм, нэгж эрхийн танилцуулгад заасан мөнгөн хөрөнгө, эсхүл актив хөрөнгийг төвлөрүүлсэн тухай хөрөнгө хадгалах

гэрээ байгуулсан кастодианы тодорхойлолт;

7.3.2. хамтын нээлттэй, хаалттай, биржээр арилжаалагддаг ХОС-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, сангийн дүрэм;

7.3.3. ХОМК-тай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, хамтын нээлттэй ХОС-ийн хувьд нэгж эрхийн танилцуулга, хамтын хаалттай болон биржээр арилжаалагддаг ХОС-ийн хувьд арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлж, тамга дарсан нэгж эрхийн танилцуулгын эх хувь;

7.4. Хороо энэ журмын 7.3-т заасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор хамтын ХОС-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

7.5. Хороо дор дурдсан нөхцөл хангагдсан тохиолдолд хамтын ХОС-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно:

7.5.1. хамтын ХОС-ийн дүрэм, нэгж эрхийн танилцуулгад заасан хөрөнгө, санхүүгийн хэрэгслийг тусгаарласан дансанд бүрэн төвлөрүүлж, нэгж эрхийн өмчлөх эрхийг кастодианаар баталгаажуулсан;

7.5.2. хамтын нээлттэй болон хаалттай ХОС-ийн хувьд нийтэд санал болгон нэгж эрх гаргах ажиллагаа амжилттай явагдсан гэж үзсэн, ХОМК нь нэгж эрхийн захиалга хүлээн авах программтай, кастодианд тусгайлсан данс нээсэн байх шаардлагыг хангасан;

7.5.3. хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн хувьд нэгж эрхийг анхдагч зах зээлд санхүүгийн хэрэгслээр солих ажиллагаа амжилттай явагдсан гэж үзсэн;

7.5.4. энэ журамд заасан шаардлагыг хангасан;

7.5.5. хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлж болох буюу тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах өөр бусад үндэслэлгүй.

7.6. Хороо энэ журмын 7.4-т заасан хамтын ХОС-д үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шийдвэрт сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тусгасан байна.

7.7. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.9-д заасны дагуу Хороо хамтын ХОС-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноор тухайн сангийн үйл ажиллагаа эхлэх бөгөөд уг өдрөөс ХОМК-д хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх нээгдэнэ.

7.8. Хамтын ХОС-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор холбогдох бүртгэлийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.

7.9. Хамтын ХОС-ийн удирдлага, эсхүл хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж байгаа ХОМК нь дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд хамтын ХОС-ийн үйл ажиллагааг түдгэлзүүлж, нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах бөгөөд энэ тухай Хороонд тухай бүр мэдэгдэнэ:

7.9.1. хамтын ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, үйлчилгээ үзүүлж байгаа ХОМК, кастодиан нь тохиромжтой этгээдийн шаардлагыг хангахгүй болсон;

7.9.2. хамтын ХОС-г татан буулгах нөхцөл байдал үүссэн;

7.9.3. нэгж эрх эзэмшигчдийн хурлыг заавал зарлан хуралдуулах нөхцөл байдал үүссэн;

7.10.4. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, холбогдох бусад хууль болон энэ журамд заасан үндэслэл бий болсон.

7.10. Хамтын ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох нь тухайн санг татан буулгах үндэслэл болох бөгөөд сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл нь нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ажлын 15 өдрийн дотор

зарлан хуралдуулж хамтын санг татан буулгах ажиллагааг гүйцэтгэнэ.

7.11. Хороо нь хамтын ХОС-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх болон хүчингүй болгох тухай шийдвэрийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлнэ.

Найм. ХОС-ийн удирдлага, бүтэц зохион байгуулалт

8.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу ХОС-ийн эрх барих дээд байгууллага нь сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал байна.

8.2. Энэ журмын 2.3.3, 2.4.4-т тус тус заасан ХОС-ийн дүрэмд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд зааснаас гадна нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын дараах бүрэн эрхийг тусгасан байна:

8.2.1. төлөөлөн удирдах зөвлөлгүй ХОС-ийн хувьд ХОМК-ийг сонгох, хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээ байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэр гаргах;

8.2.2. төлөөлөн удирдах зөвлөлгүй ХОС-ийн хувьд кастодианыг сонгох, хөрөнгө хадгалах гэрээ байгуулах шийдвэр гаргах;

8.2.3. төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт;

8.2.4. төлөөлөн удирдах зөвлөлийн хараат болон хараат бус гишүүдийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

8.2.5. ХОС-ийн гишүүд сангийн нэгж эрхээр гэрчлэгдсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх болон сангийн хөрөнгийг зохих ёсоор удирдахыг шаардах эрхтэй холбоотой зохицуулалт.

8.3. ХОС-ийн дүрэмд өөрөөр заагаагүй бол сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын чөлөөт цагт эрх барих дээд байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.

8.4. Сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хамтын ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь 5-аас доошгүй гишүүнтэй, тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх бөгөөд уг гишүүд нь Компанийн тухай хууль, Хорооноос баталсан компанийн засаглалын кодекс болон холбогдох бусад хууль, журамд заасан шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

8.5. Хамтын ХОС-ийн хувьд төлөөлөн удирдах зөвлөл хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг ХОМК-тай байгуулах бөгөөд хувийн ХОС-ийн хувьд холбогдох үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулахтай холбоотой харилцааг сангийн дүрмээр зохицуулна.

8.6. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9.7-д заасны дагуу ХОС-ийн гүйцэтгэх удирдлагын өдөр тутмын чиг үүргийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр ХОМК эрхлэн гүйцэтгэнэ.

Ес. ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал

9.1. ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуулийн 59.4-т заасан хугацаанд хуралдуулаагүй тохиолдолд тухайн сангийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх дуусгавар болсонд тооцох ба тэдгээрийн байгуулсан аливаа гэрээ, хэлцэл, гаргасан шийдвэр нь хүчин төгөлдөр бус байна.

9.2. Хамтын ХОС-ийн хувьд нэгж эрх эзэмшигч гишүүдийн ээлжит хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн дараах асуудлаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах:

9.2.1. ХОС-ийн жилийн үйл ажиллагааны болон аудит хийлгэсэн санхүүгийн тайлан;

9.2.2. кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан;

9.2.3. ХОМК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны

тайлан;

9.2.4. ХОС-ийн дүрэмд заасан бусад асуудал.

9.3. ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал хуралдуулахтай холбогдсон зардлыг тухайн ХОС бүрэн хариуцна.

9.4. ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хуралд тухайн сангийн гишүүд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд цахим хэлбэрээр, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож болох бөгөөд энэ тохиолдолд ХОМК нь гишүүдийг хуралд цахим хэлбэрээр оролцох бололцоог хангасан байна.

9.5. ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 61.1.1-61.1.3, 61.1.5-д заасан нөхцөл үүссэн болон ХОС-ийн дүрэмд заасан бусад асуудлаар нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болох бөгөөд энэ тохиолдолд Компанийн тухай хуульд заасан шаардлагыг баримтална.

9.6. ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал болохоос 14 ба түүнээс дээш өдрийн өмнө хурал зохион байгуулагч этгээд нь хурлын тов болон холбогдох мэдээллийг сангийн гишүүдэд цахим шуудан болон бусад арга хэлбэрээр дамжуулан хүргүүлнэ.

9.7. ХОС-ийн нийт гаргасан нэгж эрхийн 50 ба түүнээс дээш хувийг эзэмшигч оролцсон тохиолдолд тухайн сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг хүчин төгөлдөр болсонд тооцно.

9.8. Энэ журмын 9.7-д заасан ирц бүрдээгүй бол тухайн ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг товлох бөгөөд сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг дахин хуралдуулахтай холбоотой харилцааг сангийн дүрмээр зохицуулна.

Арав. ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөл

10.1. ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу хурлаа хуралдуулж, уг шаардлагыг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж ажиллана.

10.2. ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь ХОМК-тай байгуулсан гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж, нэгж эрх эзэмшигчдийн үндсэн болон нэмэлт эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, сангийн үйл ажиллагаанд сонирхлын зөрчил болон онцгой нөхцөл байдал үүсэхээс сэргийлж ажиллана.

10.3. Хамтын болон хувийн ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат болон хараат бус гишүүд нь нэгж эрх эзэмшигч гишүүдийг төлөөлөх итгэмжлэлийн үүргээ тогтмол биелүүлж, тэдгээрийн эрх ашгийг хамгаалж ажиллана.

10.4. Сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хамтын хаалттай ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь нийтэд санал болгон нэмж нэгж эрх гаргах шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэртэй нийт гаргах нэгж эрхийн тоо ширхэг, үнэ, татан төвлөрүүлэх хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөө зэргийн талаар тусгана.

10.5. Хамтын нээлттэй ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд сангийн активт тавих шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, хөрвөх чадварын түвшин болон санд нэгж эрхээ буцаан худалдах нэгж эрхийн төлбөрийг төлөх, буцаан худалдахад тавих хязгаарлалт зэргийг зохицуулж буй холбогдох журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, энэ талаар нэгж эрх эзэмшигч гишүүдэд тогтмол мэдээлнэ.

10.6. Хамтын ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь сангийн нэгж эрхийн тооцоолол, цэвэр активын үнэлгээ, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, аудитын дүгнэлтэд хяналт тавьж, зөрчил дутагдал гарсан нөхцөлд энэ талаар төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд

танилцуулж, зөрчлийг арилгах чиглэлээр шийдвэр гаргуулна.

10.7. Хамтын ХОС-ийн хувьд санг татан буулгах нөхцөл бүрдсэн, эсхүл санг нэгтгэх, нийлүүлэх тохиолдолд сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн ээлжит бус хурлыг нэн даруй зарлан хуралдуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

10.8. ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үр дүнд бий болсон хуримтлагдсан ашгаас нэгж эрх эзэмшигч гишүүдэд ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг Компанийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж, ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ талаар нэгж эрх эзэмшигч гишүүдийн хуралд танилцуулна.

10.9. Хуульд өөрөөр заагаагүй бол ХОМК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь хамтын ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний ажлыг давхар хавсран эрхлэхгүй.

Арван нэг. ХОС-ийн гүйцэтгэх удирдлага

11.1. Хамтын ХОС-ийн гүйцэтгэх удирдлагын эрх үүргийг хамтран ажиллах гэрээний хүрээнд хоёроос дээш ХОМК хэрэгжүүлж болно.

11.2. Сангийн гүйцэтгэх удирдлагын өдөр тутмын эрх үүргийг хэрэгжүүлж буй ХОМК нь удирдаж буй ХОС-тай аливаа сонирхлын зөрчил үүсгэхээс сэргийлж ажиллах үүрэгтэй бөгөөд хөрөнгө оруулалтын бодлого, стратегийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

11.3. Хамтын ХОС-д үйлчилгээ үзүүлж буй ХОМК нь тухайн сангийн нэгж эрхийг тооцоолж, цэвэр активыг үнэлэх, сангийн активын хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллана.

11.4. Хамтын нээлттэй ХОС-ийн хувьд ХОМК нь сүүлийн 5 жилийн хугацаанд эзэмшсэн, буцаан худалдаж авсан, хүчингүй болгосон нэгж эрх, түүний активын багцын бүртгэл, үлдэгдлийн тооцоог холбогдох үнэлгээний аргачлал, тооцооллын хамтаар хөтлөн өөрийн архивт хадгална.

11.5. ХОМК нь энэ журмын 11.4-т заасан бүртгэлийг Хороо, тухайн сангийн төлөөлөн удирдах зөвлөл, хөрөнгө хадгалах үйлчилгээ үзүүлж байгаа кастодианаас ирүүлэх хүсэлт, шаардлагын дагуу үнэ төлбөргүйгээр танилцуулах, холбогдох хэсгийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр гаргаж өгөх үүрэгтэй.

11.6. Хувийн ХОС-д үйлчилгээ үзүүлж буй ХОМК нь холбогдох журамд заасан хугацаанд сангийн цэвэр активын үнэлгээг тооцох, хөрөнгө хадгалагч кастодианд сангийн хөрөнгийг хадгалах, нэгж эрхийн үнийн мэдээллийг хөрөнгө оруулагчид хүргэх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллана.

11.7. Хамтын ХОС-д үйлчилгээ үзүүлж буй ХОМК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг дараах тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр цуцална:

11.7.1. Шүүх болон эрх бүхий төрийн байгууллагаас тухайн ХОМК-ийг татан буулгах тухай шийдвэр гаргасан;

11.7.2. ХОМК сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, стратегид заасны дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахгүйгээр нэгж эрх эзэмшигч гишүүдийн эрх ашгийг хохироох нөхцөлийг үүсгэсэн;

11.7.3. сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр гэрээг цуцлах, дуусгавар болгох шийдвэр гаргасан;

11.7.4. Хорооноос эрх хүлээн авагчийг томилсон;

11.7.5. ХОС-ийн дүрэм болон гэрээнд заасан бусад тохиолдолд.

Арван хоёр. ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн бүртгэл, түүний эрх, үүрэг

12.1. ХОМК нь тухайн ХОС-ийн гишүүний бүртгэлийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 22.1-д заасны дагуу кастодианы сангийн нэгж эрхийн тухайлсан бүртгэлд үндэслэн хөтөлнө.

12.2. ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүн нь иргэн бол Компанийн тухай хуулийн 45.3-т заасан мэдээлэл, хуулийн этгээд бол оноосон нэр, тэдгээрийн регистрийн дугаар, түүний эзэмшилд байгаа нэгж эрхийн тоог тухайлсан бүртгэлд тусгана.

12.3. ХОС-ийн дүрэм болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд өөрөөр заагаагүй бол ХОМК нь сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн бүртгэлийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

12.4. ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүд нь дараах эрх, үүрэгтэй:

12.4.1. хуульд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх бөгөөд нэг нэгж эрх нэг саналын эрхийг хэрэгжүүлэх;

12.4.2. хамтын хаалттай, нээлттэй ХОС-ийн хувьд сангийн нийт гаргасан нэгж эрхийн 1 хувиас дээш хувийг эзэмшигч нь нэгж эрх эзэмшигч гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах санал, шаардлагыг ХОМК, төлөөлөн удирдах зөвлөлд гаргах;

12.4.3. энэ журмын 12.4.2-т заасан этгээд нь ХОМК, кастодианы үйл ажиллагааг зогсоох, түүнийг өөрчлөх тухай асуудлыг төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл сангийн гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх санал гаргах;

12.4.4. холбогдох хууль тогтоомж болон ХОС-ийн дүрэмд заасан бусад.

Арван гурав. Хамтын нээлттэй болон хаалттай ХОС-ийн үйл ажиллагаа

13.1. Хамтын нээлттэй ХОС-ийн хувьд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлж буй ХОМК нь сангийн дүрэм болон нэгж эрхийн танилцуулгад тусгасан нийт зарласан нэгж эрхийн тооны хязгаарын хүрээнд эрэлтийн хэмжээгээр нэгж эрхээ хөрөнгө оруулагчдад санал болгон худалдаж, эргүүлэн худалдан авах ажиллагааг тогтмол зохион байгуулна.

13.2. Хамтын нээлттэй ХОС-ийн хувьд сангийн дүрэм, нэгж эрхийн танилцуулга болон холбогдох журмуудад сангийн активын бүрэлдэхүүнд оруулах санхүүгийн хэрэгслийн төрөл, тоо хэмжээ, хөрөнгө оруулагч нэгж эрх худалдан авах, эсхүл нэгж эрхээ санд буцаан худалдахад тавигдах нөхцөл, шаардлага, төлөх шимтгэл, хураамж, захиалгыг биелүүлэх хугацаа, захиалгыг түдгэлзүүлэх нөхцөлийн талаар дэлгэрэнгүй тусгасан байна.

13.3. Хамтын нээлттэй ХОС-ийн хувьд үйлчилгээ үзүүлж буй ХОМК нь сангийн хөрөнгөөр үр ашигтай хөрөнгө оруулалт хийж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хөрөнгийн удирдлагыг зохистой түвшинд хэрэгжүүлэх замаар активт тавих шаардлага болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол хангана.

13.4. Сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хамтын нээлттэй ХОС нь сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлсэн өдрөөс хойш 1 сарын хугацаанд нэгж эрх эзэмшигчийн нэгж эрхээ санд буцаан худалдах хүсэлтийг түдгэлзүүлж болно.

13.5. Энэ журмын 13.1-д заасны дагуу хамтын нээлттэй ХОС нь өөрийн нэгж эрхийг буцаан худалдан авах шаардлагыг хэрэгжүүлэх тохиолдолд мөнгөн хөрөнгөөр худалдан авах бөгөөд сангийн дүрэм болон нэгж эрхийн танилцуулгад өөрөөр заагаагүй бол мөнгөн хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд сангийн активт байгаа санхүүгийн хэрэгслээр буцаан худалдан авч болно.

13.6. Хамтын нээлттэй ХОС нь активт тавих шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны ашигт ажиллагааг бууруулахгүй байх хүрээнд

тухайн нэгж эрх эзэмшигчийн нэгээс дээш хэд хэдэн удаагийн худалдах, худалдан авах захиалгыг цуцалж болох ба нэг өдөрт хийгдэх хэд хэдэн удаагийн арилжааг хориглохтой холбоотой зохицуулалтыг сангийн үйл ажиллагааны холбогдох журмуудад тусгаж болно.

13.7. ХОМК нь хамтын ХОС-ийн активыг гуравдагч этгээдийн өмнө үүргийн гүйцэтгэлийг хангуулах болон өмчлөх эрхийн зөрчилтэй аливаа санхүүгийн хэрэгслээр бүрдүүлэхгүй байх шаардлагыг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөнө.

13.8. Хамтын хаалттай болон нээлттэй ХОС нь бусдад мөнгөн хэлбэрээр зээл олгохгүй бөгөөд энэ журмаар тогтоосон сангийн активт тавих шаардлага, зохистой харьцааны шалгуурыг хангаж байх нөхцөлд сангийн активт оруулсан санхүүгийн хэрэгслээр бусдад зээл олгож болно.

13.9. ХОМК нь хамтын нээлттэй болон хаалттай ХОС-ийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөнө:

13.9.1. ХОС-ийн хөрөнгө нь тухайн сангийн дүрэмд тусгасан болон Хорооноос тогтоосон нөхцөл шалгуурыг хангаж байгаа талаар байнгын хяналтыг хэрэгжүүлж ажиллах;

13.9.2. кастодианы үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний эрхийн хүрээнд хяналт тавих;

13.9.3. кастодианыг өөрчлөх, өөр кастодианд хөрөнгийг хадгалах эрхийг олгох тохиолдолд уг ажиллагааг эрсдэлгүй зохион байгуулах, шаардлагатай зөвлөмж, удирдлагаар хангах;

13.9.4. ХОС-ийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийсэн бүхий л гүйлгээнд тухай бүр хяналт тавьж, эрсдэлийг тооцох;

13.9.5. ХОС-ийн дүрэм, нэгж эрхийн танилцуулга, бодлогын баримт бичигт зааснаас илүү хэмжээний, эсхүл тэдгээрт заагдаагүй зардал, төлбөрийг сангийн хөрөнгөөс гүйцэтгэхгүй байх;

13.9.6. ХОС-ийн дүрэм, нэгж эрхийн танилцуулга, холбогдох журамд заасны дагуу нэгж эрх эзэмшигч гишүүдийг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах;

13.9.7. энэ журам болон Хорооноос тогтоосон бусад шаардлагыг мөрдөн ажиллах.

13.10. Хамтын нээлттэй ХОС-ийн хувьд цэвэр активын үнэлгээг дараа өдрийн 10 цагийн дотор өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх бол хамтын хаалттай ХОС-ийн хувьд арилжаа эрхлэх байгууллагын арилжаа явуулах цаг дууссанаас хойш 22 цагийн дотор арилжаа эрхлэх байгууллагын болон өөрийн цахим хуудсаар дамжуулан тус тус олон нийтэд мэдээлнэ.

13.11. ХОМК нь Хорооноос баталсан холбогдох журам, зааварт заасан шаардлагын дагуу сангийн цэвэр активын үнэлгээг санхүүгийн хэрэгсэл төрөл тус бүрээр бодитой тооцох ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд сангийн цэвэр активын үнэлгээг бодит үнэ цэнээс хэт доогуур, эсхүл дээгүүр үнэлэх замаар аливаа сонирхлын зөрчил гаргахаас сэргийлж ажиллана.

13.12. Энэ журмын 13.11-д заасан сангийн цэвэр активын үнэлгээг тооцохтой холбоотой нарийвчилсан арга аргачлалын талаар сангийн дүрэм, холбогдох үйл ажиллагааны журамдаа тусгах бөгөөд уг үнэлгээг тооцохдоо бодит үнэ цэнэ, зах зээлийн үнэ цэнийн аргачлал болон санхүүгийн загварчлалыг ашиглаж болно.

13.13. Хуульд өөрөөр заагаагүй бол онцгой нөхцөл байдал болон давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан хамтын ХОС-ийн үйл ажиллагаанд гарах хохирлыг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж буй ХОМК хариуцахгүй.

13.14. ХОМК, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч нь хамтын ХОС-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж болон Хорооноос баталсан журмын дагуу гүйцэтгэнэ.

13.15. Хамтын ХОС-ийн дүрэм болон нэгж эрхийн танилцуулгад ХОМК-д төлөх үйлчилгээний хөлс,

урамшууллын хувь хэмжээ болон түүний дээд хязгаарын талаар дэлгэрэнгүй тусгах бөгөөд нэгж эрхэд ногдох цэвэр активын үнэлгээ нь нэгж эрхийн нэрлэсэн үнээс илүү гарсан нөхцөлд ХОМК-д заасан хувь хэмжээгээр урамшууллыг олгож болно.

13.16. Хамтын нээлттэй ХОС-ийн хувьд ХОМК нь нэгж эрхийн үнийг цэвэр активын үнэлгээгээр тогтоосны үндсэн дээр энэ журмын 13.1-д заасны дагуу сангийн нэгж эрхийг хөрөнгө оруулагчдад худалдах ажиллагааг хэрэгжүүлнэ.

13.17. Хамтын нээлттэй ХОС-ийн хувьд нэгж эрх эзэмшигчдийн нэгж эрхээ санд буцаан худалдах захиалгыг түдгэлзүүлэх нөхцөл үүссэн тохиолдолд сангийн дүрэм, нэгж эрхийн танилцуулга болон холбогдох журмуудад заасны дагуу холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах ба энэ талаар нэгж эрх эзэмшигч, олон нийтэд өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр мэдээлж, холбогдох мэдээллийг ажлын гурван өдрийн дотор Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлнэ.

13.18. Хамтын нээлттэй ХОС-ийн хувьд ХОМК нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ журмын 13.17-д зааснаас гадна улс төр, нийгэм, эдийн засаг, дотоод, гадаадын санхүүгийн зах зээлтэй холбоотой онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэгж эрхийг санд буцаан худалдах захиалгыг түдгэлзүүлэх, хугацааг сунгах эсэх, цуцлах нөхцөл, хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулж болно.

Арван дөрөв. Хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн үйл ажиллагаа

14.1. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж буй ХОМК нь тухайн сангийн активын багцын удирдлагыг хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, нэгж эрхийн танилцуулгад заасан хөрөнгө оруулалтын стратегийг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж, сангийн нэгж эрхийг шинээр үүсгэх, нэгж эрхээ буцаан худалдан авах ажиллагааг арилжаа эрхлэх байгууллагын арилжаа явуулах өдөр бүр зохион байгуулж ажиллана.

14.2. Энэ журмын 14.1-д заасан сангийн нэгж эрхийг шинээр үүсгэх, нэгж эрхээ буцаан худалдан авах ажиллагаа нь биржийн гадуур буюу арилжаа эрхлэх байгууллагын тухайн өдрийн арилжаа явуулах цаг дууссанаас хойш хийгдэх бөгөөд уг ажиллагааг ХОМК болон хамтын биржээр арилжаалагддаг ХОС-тай гэрээ байгуулсан мэргэжлийн оролцогч хамтран хэрэгжүүлнэ.

14.3. Сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд шинээр нэгж эрх үүсгэх, нэгж эрхээ буцаан худалдах ажиллагаанд хоёроос доошгүй мэргэжлийн оролцогч оролцох бөгөөд мэргэжлийн оролцогч тус бүрийн чиг үүргийг энэ журмын 6.4-т заасан гэрээнд дэлгэрэнгүй тусгасан байна.

14.4. Хамтын биржээр арилжаалагддаг ХОС нь хоёрдогч зах зээлд шинээр нэгж эрх үүсгэх хүрээнд солилцох санхүүгийн хэрэгслийн болон нэгж эрхээ буцаан худалдах тоо хэмжээний талаар арилжаа эрхлэх байгууллага болон өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд мэдээлж, ил тод байдлыг хангаж ажиллана.

14.5. Хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг зохион байгуулах, мэргэжлийн оролцогчид тавих шалгуурыг тогтоох, сангийн нэгж эрхийн хөрвөх чадварын шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавихтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан журмыг арилжаа эрхлэх байгууллага тогтоож, Хороогоор батламжлуулна.

14.6. Кастодиан нь хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн актив болон нэгж эрх эзэмшигч өөрчлөгдөх тухай бүр холбогдох өөрчлөлтийг хийж, эзэмшигч тус бүрээр бүртгэл хөтөлж, нэгж эрх, сангийн активын багцад байгаа санхүүгийн хэрэгслийг хадгалах, шилжүүлэх, цэвэр активын үнэлгээний тооцоололд хяналт тавьж ажиллана.

14.7. ХОМК нь сангийн нэгж эрхийг шинээр үүсгэх ажиллагааг мэргэжлийн оролцогчтой хамтран

хэрэгжүүлэхдээ сангийн активыг гуравдагч этгээдийн өмнө үүргийн гүйцэтгэлийг хангуулах болон өмчлөх эрхийн зөрчилтэй аливаа санхүүгийн хэрэгслээр солилцохгүй байх шаардлагыг тогтмол мөрдөж ажиллана.

14.8. Хамтын биржээр арилжаалагддаг ХОС нь бусдад мөнгөн хэлбэрээр зээл олгохгүй.

14.9. Хамтын биржээр арилжаалагддаг ХОС-д холбогдох гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлж буй ХОМК, кастодиан, мэргэжлийн оролцогч нь Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-аас биржээр арилжаалагддаг сангийн талаар гаргасан зөвлөмж, зарчмыг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөнө.

14.10. ХОМК нь ХОС-ийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөнө:

14.10.1. ХОС-ийн хөрөнгө нь тухайн сангийн дүрэмд тусгасан болон Хорооноос тогтоосон нөхцөл шалгуурыг хангаж байгаа талаар байнгын хяналтыг хэрэгжүүлж ажиллах;

14.10.2. кастодианы үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний эрхийн хүрээнд хяналт тавих;

14.10.3. кастодианыг өөрчлөх, өөр кастодианд хөрөнгийг хадгалах эрхийг олгох тохиолдолд уг ажиллагааг эрсдэлгүй зохион байгуулах, шаардлагатай зөвлөмж, удирдлагаар хангах;

14.10.4. ХОС-ийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийсэн бүхий л гүйлгээнд тухай бүр хяналт тавьж, эрсдэлийг тооцох;

14.10.5. ХОС-ийн дүрэм, нэгж эрхийн танилцуулга, бодлогын баримт бичигт зааснаас илүү хэмжээний, эсхүл тэдгээрт заагдаагүй зардал, төлбөрийг сангийн хөрөнгөөс гүйцэтгэхгүй байх;

14.10.6. ХОС-ийн дүрэм, нэгж эрхийн танилцуулга, холбогдох журамд заасны дагуу нэгж эрх эзэмшигч гишүүдийг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах;

14.10.7. энэ журам болон Хорооноос тогтоосон бусад шаардлагыг мөрдөн ажиллах.

14.11. Хуульд өөрөөр заагаагүй бол онцгой нөхцөл байдал болон давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан ХОС-ийн үйл ажиллагаанд гарах хохирлыг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж буй ХОМК хариуцахгүй.

14.12. ХОМК, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч нь хамтын ХОС-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж болон Хорооноос баталсан журмын дагуу гүйцэтгэнэ.

14.13. Сангийн дүрэм болон нэгж эрхийн танилцуулгад ХОМК-д төлөх үйлчилгээний хөлс, урамшууллын хувь хэмжээ болон түүний дээд хязгаарын талаар дэлгэрэнгүй тусгах бөгөөд нэгж эрхэд ногдох цэвэр активын үнэлгээ нь нэгж эрхийн нэрлэсэн үнээс илүү гарсан нөхцөлд ХОМК-д заасан хувь хэмжээгээр урамшууллыг олгож болно.

14.14. Хамтын биржээр арилжаалагддаг ХОС нь өөрийн нэгж эрхийн хөрвөх чадварыг тогтмол хангуулах зорилгоор арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй зах зээл үүсгэгчийг гэрээний үндсэн дээр ажиллуулж болно.

14.15. Энэ журмын 14.14-т заасан зах зээл үүсгэгчээр сангийн нэгж эрхийн хөрвөх чадварыг хангуулах ажиллагааг гүйцэтгүүлж буй тохиолдолд холбогдох гэрээг байгуулсан өдрөөс хойш уг зах зээл үүсгэгчийн талаарх мэдээллийг ажлын гурван өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

Арван тав. Хувийн ХОС-ийн үйл ажиллагаа

15.1. ХОМК нь Хорооноос баталсан холбогдох журам, зааварт заасан шаардлагын дагуу сангийн цэвэр активын үнэлгээг гүйцэтгэх бөгөөд санхүүгийн хөшүүрэг хэрэглэсэн, эсхүл үнэт цаасны

үнийн бууралтаас ашиг хүртэх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын хэрэгслийг сангийн активт оруулж болно.

15.2. Сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувийн ХОС нь сангийн хөрөнгийг барьцаалан зээл авч болох бөгөөд мөнгөн хэлбэрээр зээл олгохгүй.

15.3. Сангийн хөрөнгийн бүртгэлийг ХОМК эрх бүхий кастодианы тухайлсан бүртгэлд үндэслэн хөтлөн явуулах ба уг ажиллагааны гүйцэтгэлийн талаар үйл ажиллагааны тайланд тусгана.

15.4. Хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлж буй ХОМК нь сангийн хөрөнгийг сангийн дүрэм, нэгж эрхийн танилцуулгад зааснаас өөр зориулалтаар ашиглаж, нэгж эрх эзэмшигч гишүүдийн оруулсан хөрөнгөд хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.

15.5. Хуульд өөрөөр заагаагүй бол онцгой нөхцөл байдал болон давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан сангийн үйл ажиллагаанд үүсэх хохирлыг хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлж буй ХОМК хариуцахгүй.

15.6. ХОМК, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч нь сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж болон Хорооноос баталсан журмын дагуу гүйцэтгэнэ.

15.7. Сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол сангийн нэгж эрх эзэмшигч гишүүд санг үүсгэн байгуулагч ХОМК-тай хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулснаар уг санг төлөөлөх эрх ХОМК-д үүснэ.

15.8. Сангийн дүрэм болон нэгж эрхийн танилцуулгад ХОМК-д төлөх үйлчилгээний хөлс, урамшууллын хувь хэмжээний талаар тусгах бөгөөд сангийн нэгж эрхэд ногдох цэвэр активын үнэлгээ нэгж эрхийн нэрлэсэн үнээс илүү гарсан нөхцөлд ХОМК-д урамшууллыг олгоно.

15.9. Сангийн актив нь үл хөдлөх хөрөнгөөр бүрдсэн ХОС-ийн хувьд шаардлагатай тохиолдолд активын багцад байгаа хөрөнгөө тусгай зөвшөөрөлтэй хөрөнгийн үнэлгээчин, эсхүл хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар үнэлүүлж, цэвэр активын үнэлгээг гаргуулж болно.

15.10. Энэ журмын 15.9-д заасан этгээд нь ХОМК, кастодиан, аудитын компани болон тэдгээрийн ажилтан, нэгдмэл сонирхолтой этгээдтэй аливаа сонирхлын зөрчил үүсгэлгүйгээр хөрөнгийн үнэлгээ хийх ажиллагааг хэрэгжүүлнэ.

15.11. Хувийн ХОС нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1.9-д зааснаар үүсмэл санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болох бөгөөд энэ тохиолдолд хөрөнгө оруулах нийт дүн нь сангийн цэвэр активын 5 хувиас хэтрэхгүй байна.

Арван зургаа. Хамтын ХОС-ийн активт тавих шаардлага

16.1. Хамтын ХОС-г хөрөнгө оруулалтын стратегиас нь хамааруулан хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг болон нэгж эрхийн танилцуулгад дараах байдлаар ангилж тусгасан байна:

16.1.1. хувьцааны сан буюу арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаанд хөрөнгө оруулах сан;

16.1.2. тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн сан буюу Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга, нийтэд санал болгон гаргасан компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг тогтмол мөнгөн урсгал авах боломжтой санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сан;

16.1.3. тэнцвэржүүлсэн сан буюу хувьцааны болон тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн аль алинд нь хөрөнгө оруулах сан;

16.1.4. мөнгөний зах зээлийн сан буюу нэг жил хүртэлх хугацаатай тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сан;

16.1.5. үнэт цаасны индексийн сан буюу арилжаа эрхлэх байгууллагаас тооцон гаргадаг

индексийн багцад багтдаг үнэт цаасанд хөрөнгө оруулах сан.

16.2. Энэ журмын 16.1.1-д заасан ангилалтай хамтын ХОС-ийн активын бүрэлдэхүүнд дараах шаардлага тавина:

16.2.1. үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаанд оруулах хөрөнгийн нийт хэмжээ нь сангийн нийт активын 80 хувиас доошгүй байх ба үлдэх 15- аас дээшгүй хувийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.5, 26.1.8-д заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэлд, 5-аас дээшгүй хувийг мөнгөн хөрөнгөд байршуулж болно;

16.2.2. үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нэг компани, түүнтэй холбогдох этгээдийн нийт гаргасан хувьцааны 30-аас дээшгүй хувийг эзэмшиж болох бөгөөд түүнд сангийн нийт активын 25-аас дээшгүй хувиар хөрөнгө оруулах.

16.3. Энэ журмын 16.1.2-т заасан ангилалтай хамтын ХОС-ийн активын бүрэлдэхүүнд дараах шаардлага тавина:

16.3.1. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл, нийтэд санал болгон гаргасан компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хөрөнгө оруулах;

16.3.2. хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд оруулсан нийт хөрөнгө нь сангийн нийт активын 50 хувиас илүүгүй байх;

16.3.3. нэг компанийн нийтэд санал болгон гаргасан өрийн хэрэгслийн 30-аас дээшгүй хувийг эзэмшиж болох бөгөөд түүнд сангийн нийт активын 25-аас дээшгүй хувиар хөрөнгө оруулах;

16.3.4. сангийн нийт активын 85 хувиас доошгүй хувийг тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлд оруулах;

16.3.5. энэхүү журмын 16.3.3-т заасан хязгаарлалт нь Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын өрийн хэрэгсэлд хамаарахгүй.

16.4. Энэ журмын 16.1.3-т заасан ангилалтай хамтын ХОС-ийн активын бүрэлдэхүүнд дараах шаардлага тавина:

16.4.1. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл, компанийн нийтэд санал болгон гаргасан өрийн хэрэгсэл, арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаа болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хөрөнгө оруулах;

16.4.2. үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаанд оруулах хөрөнгийн дээд хязгаар нь сангийн нийт активын 60 хувиас хэтрэхгүй байх;

16.4.3. тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлд оруулах хөрөнгийн дээд хязгаар нь сангийн нийт активын 70 хувиас хэтрэхгүй байх;

16.4.4. үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нэг компани, түүнтэй холбогдох этгээдийн хувьцаа, нийтэд санал болгон гаргасан өрийн хэрэгслийн 30-аас дээш хувийг эзэмшихгүй байх бөгөөд сангийн нийт активын 25-аас дээшгүй хувиар хөрөнгө оруулах;

16.4.5. энэ журмын 16.4.5-д заасан хязгаарлалт нь Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын өрийн хэрэгсэлд хамаарахгүй.

16.5. Энэ журмын 16.1.4-т заасан ангилал зөвхөн хамтын нээлттэй ХОС-ийн хувьд хамаарах бөгөөд уг сангийн активын бүрэлдэхүүнд дараах шаардлага тавина:

16.5.1. сангийн худалдан авч болох өрийн хэрэгсэл нь хугацааны хувьд дараах нэмэлт шаардлагын аль нэгийг хангасан байна:

16.5.1.1. анх гаргах үед тогтоосон хугацаа нь 397 өдөр буюу 13 сараас илүүгүй байх;

16.5.1.2. сан худалдан авах үед үлдэгдэл хугацаа нь 397 өдөр буюу 13 сараас илүүгүй байх.

16.5.2. сангийн нийт активын 5-аас дээшгүй хувийг нэг компанийн нийтэд санал болгон гаргасан мөнгөний зах зээлийн хэрэгсэлд оруулж болно;

16.5.3. хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд оруулсан хөрөнгө нь сангийн нийт активын 10 хувиас хэтрэхгүй бөгөөд уг хязгаарлалт нь Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын өрийн хэрэгсэл болон Төв банкны үнэт цаасанд хамаарахгүй;

16.5.4. активын багцад багтаж буй хөрөнгө оруулалтын хэрэгслийн жигнэсэн дундаж хугацаа¹ нь 120 өдрөөс илүүгүй байх.

16.6. Энэ журмын 16.1.5-д заасан ангилал зөвхөн хамтын биржээр арилжаалагддаг ХОС-ийн хувьд хамаарах бөгөөд уг сангийн активт тавих шаардлага тавихгүй.

16.7. Хамтын ХОС-ийн хөрвөх чадварын шалгуур үзүүлэлтэд дараах шаардлага тавина:

16.7.1. хамтын нээлттэй ХОС-ийн хувьд сангийн нийт активын 10-аас доошгүй хувийг мөнгөн хөрөнгө, 12 сараас илүүгүй хугацаатай банкны хадгаламж, Засгийн газрын богино хугацаатай үнэт цаасанд байршуулж болно;

16.7.2. хамтын ХОС-ийн хувьд сангийн нийт активын 10-аас дээш хувийг хөрвөх чадвар муутай санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахгүй;

16.7.3. хамтын хаалттай ХОС-ийн хувьд мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн шаардлага тавихгүй.

16.8. Хамтын нээлттэй ХОС-ийн хувьд нэгж эрхээ эргүүлэн худалдах ихээхэн хэмжээний захиалга нэг дор ирсний улмаас мөнгөн хөрөнгө хүрэлцэхгүй болсон тохиолдолд Хорооны зөвшөөрлөөр цэвэр активын 10 хувиас хэтрэхгүй хэмжээнд 6 сараас дээшгүй хугацааны зээл авч болох бөгөөд уг зээлийг зөвхөн нэгж эрхээ эргүүлэн худалдан авах ажиллагаанд ашиглана.

16.9. Эдийн засгийн зөвхөн нэг салбарт хөрөнгө оруулахаар нэгж эрхийн танилцуулга, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигтээ тусгасан хамтын ХОС-ийн хувьд энэ журмын 16.2.2, 16.2.3, 16.4.4, 16.4.5-д тус тус заасан шаардлага хамаарахгүй бөгөөд сангийн нийт активын 20- оос дээшгүй хувийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.5, 26.1.8-д заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэл, эдийн засгийн өөр салбарын компанийн хувьцаанд оруулж болно.

16.10. Энэ журмын 16.9-т заасан хамтын ХОС-ийн хувьд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нэг компанийн нийт гаргасан хувьцааны 25-аас дээшгүй хувийг эзэмшиж болох бөгөөд түүнд сангийн нийт активын 15-аас дээшгүй хувиар хөрөнгө оруулж болно.

16.11. Хамтын ХОС-ийн хувьд нээлттэй хувьцаат компани хэлбэрээр зохион байгуулагдсан банкны системд нөлөө бүхий банкны хувьцаанд сангийн нийт активын 40 хүртэлх хувийг хөрөнгө оруулж болно.

Арван долоо. ХОС-ийн мэдээллийн ил тод байдал

17.1. ХОС-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлж буй ХОМК нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон энэ журмаар тогтоосон мэдээлэл, тайлагналыг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, цаг хугацаанд нь Хороо, хөрөнгө оруулагч болон олон нийтэд хүргэнэ.

¹ сангийн активын багцад байгаа өрийн хэрэгсэл тус бүрийн дуусах хугацаа, эсхүл сангийн эзэмшилд байх хугацааг сангийн багцад байгаа тухайн хөрөнгийн хувийн жингээр жигнэж гаргасан дундаж хугацаа.

17.2. Хамтын ХОС-ийн хувьд төлөөлөн удирдах зөвлөл, хувийн ХОС-ийн хувьд ХОМК нь мэдээлэл, тайлагналыг энэ журамд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж байгаа эсэхэд хяналт тавина.

17.3. ХОС нь хөрөнгө оруулагч, олон нийтэд дараах мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр мэдээлнэ:

17.3.1. нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл, танилцуулга, төлөөлөн удирдах зөвлөлийн мэдээлэл;

17.3.2. сангийн нэгж эрхийн 5 ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй нөлөө бүхий этгээдийн талаарх мэдээлэл, түүний өмчлөл дэх нэгж эрхийн тоо, хувь хэмжээ;

17.3.3. сангийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, дүрэм, журам, нэгж эрхийн танилцуулгад орсон өөрчлөлт, цэвэр активын үнэлгээний талаарх мэдээлэл;

17.3.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд тухай бүр мэдээлэхээр заасан сангийн нэгж эрхтэй холбоотой мэдээлэл;

17.3.5. хамтын нээлттэй ХОС-ийн хувьд нэгж эрхээ худалдсан болон буцаан худалдан авсантай холбоотой хийсэн хэлцэл, арилжаа, гүйлгээ, оролцогч талуудын талаарх мэдээлэл;

17.3.6. төлөөлөн удирдах зөвлөлгүй хувийн ХОС-ийн хувьд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлж буй ХОМК-ийн төлөөлөн удирдах зөвлөл, хараат бус гишүүдийн хяналтын тайлан;

17.3.7. нэгж эрх эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын мэдээлэл, төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын мэдээлэл;

17.3.8. хамтын ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд өөрчлөгдсөн, үйлчилгээ үзүүлэгч ХОМК, кастодиан, аудитын компанийг өөрчилсөн бол энэ талаарх мэдээлэл;

17.3.9. хамтын ХОС-ийн хувьд зар сурталчилгааны мэдээлэл;

17.3.10. сангийн дүрэмд заасан бусад.

17.4. ХОС нь жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг гаргах бөгөөд жилийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

17.5. Энэ журмын 17.4-т заасан жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланд дараах мэдээллийг тусгана:

17.5.1. ХОС-ийн бүтэц зохион байгуулалт, засаглал;

17.5.2. ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлого, стратеги, эрсдэл, эрсдэлийн удирдлага;

17.5.3. ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл;

17.5.4. ХОС-ийн активын багц, цэвэр активын үнэлгээ, нэгж эрхийн үнэ;

17.5.5. нэгж эрх эзэмшигч, хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад нөлөөл үзүүлэхүйц ач холбогдол бүхий мэдээлэл;

17.5.6. Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт болон хагас жилийн санхүүгийн тайлан;

17.5.7. ХОС-д холбогдох үйлчилгээг үзүүлж буй ХОМК, кастодиан, аудитын байгууллагын талаарх ерөнхий танилцуулга, тэдгээрийн тухайн сантай холбогдуулан авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайлан;

17.5.8. ХОС-ийн үйл ажиллагааны ашигт ажиллагаа, зардлын харьцаа үзүүлэлтүүд;

17.5.9. Хорооноос баталсан журам болон сангийн дүрэм, журамд заасан бусад.

17.6. ХОС нь энэ журамд заасан мэдээллийг олон нийт, хөрөнгө оруулагчид хүргэхтэй холбоотой зохицуулалтыг холбогдох журамдаа тусгаж, үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж ажиллана.

17.7. ХОС нь нэгж эрх эзэмшигч, хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийг уг нөхцөл байдал үүссэнээс хойш ажлын хоёр өдөрт багтаан мэдээлнэ.

17.8. Хамтын ХОС-ийн хувьд төлөөлөн удирдах зөвлөл, хувийн ХОС-ийн хувьд ХОМК Хороонд бүртгэлтэй аудитын компанитай үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулах бөгөөд ХОМК тухайн аудитын компанийг үүргээ гүйцэтгэхэд зохих туслалцааг үзүүлэн холбогдох мэдээллээр тухай бүр хангаж, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлж, аливаа сонирхлын зөрчил үүсгэхээс сэргийлж ажиллана.

Арван найм. ХОС-г өөрчлөн зохион байгуулах

18.1. ХОС-г Компанийн тухай хуулийн 20.1-д заасны дагуу нэгтгэж болох бөгөөд нэгтгэж буй болон нэгдэж буй сангийн хөрөнгө оруулалтын бодлого, стратеги нь хоорондоо ижил төсөөтэй байна.

18.2. ХОС-г нэгтгэх шийдвэрийг зөвхөн сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар гаргах бөгөөд нийт нэгж эрх эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

18.3. ХОМК нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд санг нэгтгэх тухай шийдвэрийн төсөл, нэгтгэх гэрээ, журмын төслийг нэгдэж байгаа сан болон нэгтгэж байгаа сан тус бүрийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар оруулж шийдвэрлүүлнэ.

18.4. Энэ журмын 18.3-г заасан нэгтгэх журмын төсөлд хоёр санг нэгтгэх ажиллагаа, эсрэг саналтай болон хуралд оролцоогүй нэгж эрх эзэмшигч санд нэгж эрхээ эргүүлэн худалдах эрх, кастодианы эрх шилжүүлэн авах эрх үүрэг зэргийн талаар дэлгэрэнгүй тусгана.

18.5. Нэгдэж байгаа ХОС тус бүрийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаас гаргасан шийдвэр, санг нэгтгэх журам, гэрээ, холбогдох баримт бичгийг ХОМК нь уг шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

18.6. Хороо энэ журмын 18.5-д заасан баримт бичгийг ажлын 20 өдрийн дотор хянаж, холбогдох хууль болон Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан гэж үзвэл тухайн санг нэгдсэнд тооцож, шийдвэрийг гаргана.

18.7. ХОМК нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон хамтын хаалттай ХОС-ийн хувьд арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс нэгдэж орсон санг хасуулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

18.8. ХОС-г нэгтгэх үйл ажиллагаатай холбоотой гарсан холбогдох зардлыг тухайн сан өөрийн хөрөнгөөр хариуцна.

18.9. ХОС-г Компанийн тухай хуулийн 19.1-д заасны дагуу нийлүүлж болох бөгөөд уг нийлүүлэх ажиллагаанд дараах шаардлага тавина:

18.9.1. үйл ажиллагааг зогсоож буй сангуудын хөрөнгө оруулалтын бодлого, стратеги ижил төсөөтэй байх;

18.9.2. сангуудын нэгж эрх эзэмшигч гишүүдийн хуралд оролцож буй нэгж эрх эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэгдсэн байх;

18.9.3. нийлүүлэх шийдвэрийг зөвшөөрөөгүй, эсхүл нэгж эрх эзэмшигч гишүүдийн хуралд оролцоогүй нэгж эрх эзэмшигч санд нэгж эрх буцаан худалдах боломжийг хангасан байх;

18.9.4. нийлүүлэх ажиллагааг гүйцэтгэхээс өмнөх сангийн санхүүгийн тайланд аудит хийлгэж, хөрөнгө хадгалагч үйлчилгээ үзүүлэгч кастодианаас дүгнэлт гаргуулсан байх.

18.10. Нийлүүлэх ажиллагааг хариуцан ажиллаж буй ХОМК нь нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаас өмнө нийлүүлэх шийдвэр, өөрчлөн байгуулах журмын төслийг боловсруулах бөгөөд уг

төсөлд сангуудыг нийлүүлснээр бий болох үр нөлөө, ашиг, шинээр бий болж буй санд нийлж буй сангуудын хөрөнгийг шилжүүлэх, нийлүүлэх ажиллагааны зардлыг хэрхэн санхүүжүүлэхтэй холбоотой мэдээллийг тусгасан байна.

18.11. Нийлж байгаа сангийн ХОМК нь шинээр бий болж буй сангийн дүрмийн төсөл, сан тус бүрийн нэгж эрхийг шинээр бий болсон сангийн нэгж эрхэд хөрвүүлэх журмыг боловсруулж, нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаар батлуулах бөгөөд уг сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаар тухайн шинээр үүсэж буй сангийн дүрмийг батална.

18.12. Нийлж байгаа сан тус бүрийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаас гаргасан шийдвэр, санг нэгтгэх журам, гэрээ, холбогдох баримт бичгийг ХОМК нь уг шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

18.13. Хороо энэ журмын 18.12-т заасан баримт бичгийг ажлын 20 өдрийн дотор хянаж, холбогдох хууль болон Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан гэж үзвэл тухайн санг нийлсэнд тооцож, шийдвэрийг гаргана.

18.14. ХОМК нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон хамтын хаалттай ХОС-ийн хувьд арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс нийлж буй сангуудыг хасуулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

Арван ес. Гадаад улсад бүртгэлтэй ХОС-г бүртгүүлэх

19.1. Гадаад улсад бүртгэлтэй хамтын болон хувийн ХОС нь Хороонд бүртгүүлсний үндсэн дээр Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан шаардлага, хязгаарын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж болно.

19.2. Гадаад улсад бүртгэлтэй ХОС-г Хороонд бүртгүүлэхэд дараах шаардлагыг тавина:

19.2.1. Хорооноос хүлээн зөвшөөрсөн санхүүгийн, эсхүл үнэт цаасны зах зээлийн зохицуулах байгууллагаас ХОС-ийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрөлтэй байх;

19.2.2. Монгол Улсад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай санхүү, хүний нөөцийн чадавхтай байх;

19.2.3. эрх бүхий кастодиантай байх;

19.2.4. эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд байх;

19.2.5. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх, хууль тогтоомж болон энэ журмаар тогтоосон мэдээллийг тухай бүр олон нийт, хөрөнгө оруулагч, Хороонд тухай бүр хүргүүлж ажиллах шаардлагыг хангах.

19.3. Гадаад улсад бүртгэлтэй ХОС-г бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

19.3.1. тухайн ХОС-ийн хэлбэр, төрөл, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, эрх бүхий албан тушаалтны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

19.3.2. тухайн ХОС-ийн хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой мэдээлэл, гэрчилгээний хуулбар /апостиль гэрчилгээ хийлгэсэн байна/;

19.3.3. хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон тухайн улсын эрх бүхий төрийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн хуулбар /апостиль гэрчилгээ хийлгэсэн байна/;

19.3.4. кастодиан, ХОМК нь үйл ажиллагаа эрхлэх эрхтэй болохыг нотлох хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн, эсхүл зөвшөөрлийн, гэрчилгээний хуулбар;

19.3.5. тухайн ХОС нь Монгол улсад үйл ажиллагаа эрхлэхэд татгалзах зүйлгүй болох талаар тухайн улсын эрх бүхий санхүүгийн зохицуулагч байгууллагаас авсан тодорхойлолт, сангийн эрх

барих дээд байгууллагын шийдвэрийн хуулбар;

19.3.6. хамгийн сүүлийн улирлын болон аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан.

19.4. Хороо хүсэлтийг бүрдэл бүрэн баримт бичгийн хамт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 20 өдрийн дотор бүртгэх эсэхийг шийдвэрлэх бөгөөд баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт тодруулга, мэдээлэл шаардлагатай тохиолдолд Хороо албан бичгээр хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

19.5. Энэ журмын 19.4-г заасан Хорооны шийдвэрт хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх хүрээ, үйл ажиллагаандаа мөрдөх нөхцөл, шаардлагын талаар тусгана.

19.6. Хороо бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ талаар хүсэлт гаргагчид ажлын таван өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

Хорь. ХОС-г татан буулгах ажиллагаа

20.1. ХОС-г Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу сайн дурын үндсэн дээр татан буулгаж болох бөгөөд дараах тохиолдолд санг албадан татан буулгана:

20.1.1. Шүүх болон эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрээр татан буулгах шийдвэр гарсан;

20.1.2. хамтын ХОС төлбөрийн чадваргүй болж, нэгж эрх эзэмшигчдийн нэгж эрхээ санд буцаан худалдах захиалгыг биелүүлэх боломжгүй болж, дампуурсан;

20.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан нөхцөл үүссэн;

20.1.4. Хорооноос хөрөнгө оруулагчдын эрх ашиг ноцтой зөрчигдөх нөхцөл үүсэж, газар дээрх шалгалтаар татан буулгах нөхцөл бүрдсэн.

20.2. Энэ журмын 20.1-д заасны дагуу ХОС-г сайн дурын үндсэн дээр татан буулгах тохиолдолд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлж буй ХОМК нь дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

20.2.1. ХОС-ийн нэгж эрхийн эзэмшигч гишүүдийн хурлаас өмнө тухайн санг татан буулгах ажиллагааны төлөвлөгөөний талаарх мэдээллийг хүргэх бөгөөд уг төлөвлөгөөнд санг татан буулгах шалтгаан, татан буулгахад гарах зардал, сангийн цэвэр активын үнэлгээ, өр төлбөрийг төлсний дараа үлдэх хөрөнгийг хөрөнгө оруулагчид хуваарилах талаар тусгах;

20.2.2. нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаар татан буулгах ажиллагааны төлөвлөгөө, шийдвэрийн төслийг танилцуулах;

20.2.3. хамтын нээлттэй ХОС-ийн хувьд санг татан буулгах ажиллагааг гүйцэтгэх хугацаанд нэгж эрх эзэмшигч нэгж эрхээ санд буцаан худалдах ажиллагааг түр түдгэлзүүлж, хамтын хаалттай ХОС-ийн хувьд бүртгэлтэй нэгж эрхийг арилжаа эрхлэх байгууллагаас хасах ажиллагааг гүйцэтгэх;

20.2.4. ХОС-г татан буулгах ажиллагааг гүйцэтгэх явцад гүйцэтгэлийн мэдээллийг нэгж эрх эзэмшигчид тухай бүр хүргэж, сангийн цэвэр активын үнэлгээг зах зээлийн үнэлгээнд тулгуурлан бодитойгоор үнэлж, оролцогч талуудтай сонирхлын зөрчил үүсгэхээс сэргийлж ажиллах.

20.3. ХОМК санг татан буулгахтай холбоотой баримт бичгийг уг ажиллагаа хийгдэж дууссан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Хороонд ирүүлэх бөгөөд татан буулгах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэхийг ажлын 15 өдрийн дотор хянаж үзсэний дараа хамтын ХОС-ийн хувьд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, хувийн ХОС-ийн хувьд үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэн шийдвэрийг хүчингүй болгоно.

20.4. Энэ журмын 20.3-г заасан шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор тухайн ХОМК санг хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасуулж, энэ талаар холбогдох мэдээллийг Хороонд ирүүлнэ.

“Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралт

ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ БАРИМТ БИЧГИЙГ БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч ХОМК-ийн нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Хэсэг 1. Хөрөнгө оруулалтын сангийн талаарх мэдээлэл						
Хувь нийлүүлсэн хөрөнгө /төгрөгөөр/						
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="radio"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="radio"/> Гадаадын хөрөнгө оруулалттай					
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Цахим шуудангийн хаяг						
Цахим хуудас						
Удирдлага, мэргэшсэн хүний нөөцтэй холбоотой мэдээлэл:						
Нийт ажилтан, албан хаагчдын тоо						
Албан тушаал	Овог, нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар
ТУЗ-ийн дарга						
ТУЗ-ийн гишүүд						
Гүйцэтгэх удирдлага						
Мэргэшсэн нягтлан бодогч /байгаа бол/						
Бусад						
Ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн талаарх мэдээлэл						

Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ /төгрөгөөр/
Программ хангамжийн нэр төрөл	Программын зориулалт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ /төгрөгөөр/

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа мэдээлэл, нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв уг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрлийг олгоно уу.

Бид үйл ажиллагаандаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн хангаж, биелүүлж ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд /тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ./:

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Албан тушаал: _____

Утасны дугаар: _____

Өргөдөл гаргагч:

Хуулийн этгээдийн

Тэмдэг

_____ /гарын үсэг/

_____ /гарын үсгийн тайлал/

“Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”-ын 2 дугаар хавсралт

**ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Хэсэг 1. Хүсэлт гаргагчийн талаарх мэдээлэл						
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="radio"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="radio"/> Гадаадын хөрөнгө оруулалттай					
Үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн төрөл	<input type="radio"/> Нээлттэй хөрөнгө оруулалтын сан <input type="radio"/> Хаалттай хөрөнгө оруулалтын сан <input type="radio"/> Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан					
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Цахим шуудангийн хаяг						
Цахим хуудас						
Удирдлага, мэргэшсэн хүний нөөцтэй холбоотой мэдээлэл:						
Нийт ажилтан, албан хаагчдын тоо						
Албан тушаал	Овог, нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар
ТУЗ-ийн дарга						
ТУЗ-ийн гишүүд						
Гүйцэтгэх удирдлага						
Мэргэшсэн нягтлан бодогч /байгаа бол/						
Бусад						
Ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн талаарх мэдээлэл						

Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ /төгрөгөөр/
Программ хангамжийн нэр төрөл	Программын зориулалт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ /төгрөгөөр/

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа мэдээлэл, нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв уг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрлийг олгоно уу.

Бид үйл ажиллагаандаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн хангаж, биелүүлж ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд /тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ./:

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Албан тушаал: _____

Утасны дугаар: _____

Өргөдөл гаргагч:

Хуулийн этгээдийн

Тэмдэг

_____ /_____/

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны
дүгээр тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын сангийн үйл
ажиллагаатай холбоотой багц журам”-ийн гуравдугаар хавсралт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИЙГ БҮРТГЭХЭД ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "Хороо" гэх)-ноос хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, хөрөнгө оруулалтын менежментийн компани (цаашид "ХОМК" гэх)-д үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогч (цаашид "МНБ" гэх)-ийг бүртгэхэд тавигдах шаардлагыг тодорхойлох, бүртгэх, бүртгэлээс хасах, тэдгээрт хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх мэргэшсэн нягтлан бодогч нь Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журам, зааврын хүрээнд ажиллана.

1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайланг гаргах этгээд нь Монгол Улсад бүртгэлтэй мэргэшсэн нягтлан бодогч, тайлагнах хуулийн этгээд нь Хорооноос хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээд байна.

1.4. Хороонд бүртгүүлсэн МНБ нь энэхүү журмаар тавигдсан нөхцөл, шаардлагыг биелүүлж ажиллана.

1.5. ХОМК нь Хороонд бүртгүүлсэн МНБ-ийн шилжилт хөдөлгөөн, гарсан өөрчлөлтийн талаарх мэдээллийг Хороонд тухай бүр ирүүлэх үүрэгтэй.

Хоёр. Журмын нэр томъёоны тодорхойлолт

2.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд зааснаас гадна энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. "Хороонд бүртгүүлсэн мэргэшсэн нягтлан бодогч" гэж Хорооноос тавьсан шаардлагыг хангаж, Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, ХОМК-д үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогчийг;

2.1.2. "Үндсэн мэргэшсэн нягтлан бодогч" гэж ХОМК-д хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй ерөнхий нягтлан бодогчийг;

2.1.3. "Гэрээт мэргэшсэн нягтлан бодогч" гэж ХОМК-тай Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх этгээдийг;

Гурав. МНБ-ийн баримтлах зарчим

3.1. Хороонд бүртгүүлсэн МНБ нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан Нягтлан бодох бүртгэлийн зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг чанд баримтлана:

3.1.1. Монгол Улсын хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журмыг мөрдөх;

3.1.2. Ил тод, шударга, мэргэжлийн өндөр ёс зүйтэй байх;

3.1.3. Иргэн, байгууллагын нууцыг хадгалах, хамгаалах;

3.1.4. Ашиг сонирхолын зөрчлөөс зайлсхийх.

Дөрөв. Бүртгүүлэхэд тавигдах нөхцөл, шаардлага

4.1. Бүртгүүлэхийг хүсч буй МНБ нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна.

4.1.1. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт /цаашид "ММНБИ" гэх/-ийн гишүүнчлэлтэй, Монгол Улсад бүртгэлтэй хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогч байх;

4.1.2. Мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй, энэ талаар ММНБИ-ээс тодорхойлолт гаргуулсан байх;

4.1.3. Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх авсан байх;

4.1.4. Мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсан байх.

4.2. МНБ нь бүрэн эрхээ гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх бөгөөд ХОМК-тай гэрээ байгуулсан байна.

4.3. МНБ нь журмын 4.1-д заасан шаардлагыг ханган Хороонд бүртгүүлсэнээр хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

4.4. МНБ нь тухайн ХОМК-ийн гэрээт кастодиан, үнэлгээний болон аудитын компанийн эрх бүхий албан тушаалтан, үнэлгээчин, аудиторын холбогдох этгээд байхыг хориглоно.

Тав. Бүртгэх, хугацааг сунгах, бүртгэлээс хасах

5.1. Хороонд бүртгүүлэх хүсэлт гаргах:

5.1.1. Хороонд бүртгүүлэхийг хүссэн МНБ нь энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ03006-ын дагуу гаргасан өргөдлийг хоёрдугаар хавсралтад заасан хавсаргах баримт бичгийн хамт Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

5.1.2. Хороо тухайн бүртгүүлэхийг хүссэн МНБ-оос ирүүлсэн өргөдөл, баримт бичгийн бүрдлийг шалгаж, баримт хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор Хорооны удирдлагад танилцуулж, Хорооны даргын тушаалаар шийдвэрлэнэ.

5.1.3. Хороо МНБ-ийг шаардлага хангасан гэж үзвэл Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, ХОМК-д үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгэнэ.

5.2. Хороонд бүртгүүлсэн МНБ-ийн бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийг сунгах, бүртгэлээс хасуулах хүсэлт гаргах, бүртгэлээс хасах:

5.2.1. Бүртгэлийн хугацааг дуусахаас нэг сарын өмнө сунгуулах хүсэлтээ энэхүү журамд заасан шаардлагыг хангасан баримт бичгийн хамт Хороонд бичгээр ирүүлнэ.

5.2.2. Бүртгэлийн хугацаа сунгуулах тухай хүсэлтийг Хорооны Ажлын алба тухайн мэргэшсэн нягтлан бодогчийн ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнг харгалзан холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, Хорооны даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.

5.2.3. Бүртгэгдсэн этгээдийг өөрөө хүсэлт гаргасан болон дор дурдсан зөрчил гаргасан нь тогтоогдвол Хороо бүртгэлээс хасна:

5.2.3.а. Энэхүү журмын 4 дүгээр зүйлд заасан нөхцөл шаардлагын аль нэг нь хангагдахгүй болсон;

5.2.3.б. Бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

5.2.3.в. Санхүүгийн тайланг буруу тайлагнасан, дагаж мөрдвөл зохих дүрэм, журам, үйл ажиллагаанд баримтлах зарчмыг зөрчсөн, үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, түүнтэй адилтгах нөхцөл байдал үүсгэсэн;

5.2.3.г. Хороо ашиг сонирхолын зөрчил бүхий нөхцөл байдал бий болсон гэж үзсэн;

5.2.3.д. холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон.

5.2.4. Энэхүү журмын 5.2.3.а-д зааснаас бусад үндэслэлээр бүртгэлээс хасагдсан этгээдийг бүртгэлээс хасагдсанаас хойш 1 жилийн хугацаанд Хороо дахин бүртгэхээс татгалзана.

5.2.5. Хороо энэхүү журамд заасны дагуу хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, ХОМК-д үйлчилгээ үзүүлэх этгээдийг бүртгэлээс хасах, хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн этгээдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан олон нийтэд

мэдээлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.3. Хороонд бүртгүүлсэн мэргэшсэн нягтлан бодогч нь Хорооноос зөвшөөрсөн хугацаанд үйлчилгээ үзүүлэх эрхтэй байна.

5.4. Хорооны тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан нь МНБ-ийг бүртгэсэн, хугацааг нь сунгасан, бүртгэлээс хасагдсан талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, Хорооны Үнэт цаасны салбар хариуцсан нэгжид өөрчлөлт орсон тухай бүр мэдэгдэнэ.

5.5. Хороо нь шинээр бүртгэх, хугацааг нь сунгахаас татгалзах тохиолдолд үндэслэлээ хүсэлт гаргасан этгээдэд албан ёсоор хүргүүлнэ.

5.6. МНБ-ийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг шинээр бүртгэсэн, хугацааг нь сунгасан, бүртгэлээс хасагдсан тухай шийдвэрийг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан Хорооны цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

5.7. МНБ нь бүртгэлтэй хугацаандаа ММНБИ-ийн мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаагүй талаарх тодорхойлолтыг жил бүр Хороонд ирүүлнэ.

Зургаа. Санхүүгийн тайланг хүлээн зөвшөөрөх

6.1. Хороонд бүртгүүлсэн МНБ-ийн хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайланд Хорооны Үнэт цаасны хяналт шалгалтын нэгж хяналт тавина.

6.2. Хороонд бүртгэлгүй болон энэхүү журмын шаардлагыг хангаагүй нь тогтоогдсон этгээдийн гаргасан санхүүгийн тайланг Хороо хүлээн зөвшөөрөхгүй.

Долоо. Хяналт, хариуцлага

7.1. Хороо энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж, Хороонд бүртгүүлсэн МНБ-ийн аливаа хууль зөрчсөн үйл ажиллагаа тогтоогдвол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Хууль зөрчсөн үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл Хороо холбогдох байгууллагад хандаж шалгуулна.

"Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх.
үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогчийг
бүртгэх тухай журам"-ын 1 дүгээр хавсралт

Д/д	Маягтын код	Маягтын зориулалт
1	СЗХ03006	Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогчийг бүртгэх

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ХӨТЛӨХ,
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИЙГ БҮРТГЭХ,
БҮРТГЭЛИЙН МАЯГТ**

Бүртгүүлэх мэдээллийн төрлийг сонгоно уу.

1. ХОМК-ийн үндсэн ажилтан буюу мэргэшсэн нягтлан бодогч
 2. ХОМК-д үйлчилгээ үзүүлэх гэрээт ажилтан буюу мэргэшсэн нягтлан бодогч

(Тохирох нүдэнд "√" тэмдгийг тавина)

Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогчийг бүртгэх						
Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
1. Өргөдөл гаргагч						
Үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны төрлөө сонгоно уу.						
<input type="radio"/> Хамтын хөрөнгө оруулалтын сангийн мэргэшсэн нягтлан бодогч						
<input type="radio"/> Хувийн хөрөнгө оруулалтын сангийн мэргэшсэн нягтлан бодогч						
Иргэн та доорх мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.						
Овог						
Нэр						
Регистрийн дугаар						
Албан ёсны оршин суух хаяг						
Холбоо барих гар утас						
Эзэмшсэн мэргэжил						
МНБ-ийн гэрчилгээний дугаар						
Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх авсан үнэмлэхийн дугаар						
Эрхэлж байгаа ажил, албан тушаал						
Ажлын хаяг						
Хувийн цахим шуудан						
2. ХОМК-ийн мэдээлэл						
Хуулийн этгээдийн нэр	Монгол					
	Англи					
Тусгай зөвшөөрлийн огноо	Он		Сар		Өдөр	
Тусгай зөвшөөрлийн дугаар						
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Цахим хуудас						